

# ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

## 2020 №01

### New Arrivals



Эмхтгэсэн: Ном зүйч С.Найгалмаа  
Э.Рэгзэдмаа

Улаанбаатар хот  
2020 он

### ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН. ЭКОЛОГИ

Галт Л. ба бус. **Хүрээлэн буй орчны микробиологи** / П.Оюунчимэг, Ц.Нямлхагва; Ариутган шүүсэн. П.Оюунчимэг.- УБ.: Арвайбархан, 2019.- 282х.- ISBN: 978-9919-22-557-5.



Доктор домон тойн овгийн Лантуу овогтой Галт 1944 онд Говь-Алтай аймгийн тэр үеийн Түмэн, одоогийн Тайшир, Ёсөнбулаг сумын нутаг Хантайширын нурууны баруун суганд Зэлийн голын Мухар даваа хэмээх газар төржээ. Зохиолч маань уг бүтээлдээ хүрээлэн буй орчин, уур амьсгал, бичил биетэн, микробиологийн замаар энерги үүсэх, бодисын солилцоо, харилцан уялдаа, нүүрстөрөгчийн эргэлт, хүхэр, төмөр болон марганецын эргэлт, хүнд металл, органик биш бодист учрах гэмтэл, хаягдал усны биологийн цэвэрлэгээ, агаарын биологийн цэвэрлэгээний талаар тус тус дурджээ.

20.1я73

Г 201

/БУУТ-6/

ЭШФ Т-23188-23190

Сэмбээжав Б. **Хүн, мал амьтны экологи** / Ред. С.Бямбамаа, С.Бямбажаргал.- УБ.: ВСИ., 2019.- 748х.- (Мянган мэргэшлийг өвлөсөн амьдрахуйн ухаан Б.5).- ISBN: 978-9919-21-973-4.



Уг бүтээлд ХХI зууны хамгийн үнэ цэнэтэй таваар бол мал амьтны биологи-экологийн тухай мэдлэг, бүтээхуйн ухаан... аливааг хийж гүйцэлдүүлэх ур чадвар мөн болох талаар уншигч таньтай санал бодлоо солилцож, малчин өрх бүр жижиг үйлдвэр... хүн бүхэн шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч-ажил үйлчилгээ санаачлагч гэсэн тэдний амь ахуйн экологийг гадаад дотоод өнцгөөс нь тодорхойлохыг зорьжээ.

20.1

С 932

/БУУТ-4/

ЭШФ Т-23053-23055

Сономдагва Ч. **Монгол орны хотуудын хүрээлэн буй орчин**: Улаанбаатар, Дархан, Эрдэнэт: Нэг сэдэвт бүтээл / Ред. Д.Доржготов, Ч.Бямбацэрэн.- УБ.: МУИС пресс, 2019.- 251х.- ISBN: 978-9919-22-555-1.



Тус бүтээлийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын хүрээлэн буй орчны чиглэлээр сүүлийн 15 жил орчим хийсэн судалгааны ажил, хэвлэгдэн гарсан эрдэм шинжилгээний өгүүлэл тайлан, бакалавр, магистр, докторын судалгааны ажлуудын үр дүнд тулгуурлан туурвижээ.

20.18(1)


С 582

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-23065-23067

### ФИЗИК, МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Шилагарди Г., Мөнхцэцэг С. **Хагас дамжуулагчийн физик**: 1-р дэвт.- Мэргэжлийн суурь боловсрол эзэмшихэд зориулсан их сургуулийн сурах бичиг / Хэвлэлийн эх бэлт. С.Мөнхцэцэг; Ред. П.Түвшинтөр, Б.Бадамханд.- УБ.: МУИС пресс, 2020.- 130х.- ISBN: 978-9919-23-062-3.



Тус бүтээл нь "Онолын асуудал", "Электроникийн багаж хэрэгслийн онолын үндэс суурь", "Хэрэглээний асуудал" гэсэн гурван дэвтрээс бүрдэнэ. Энэхүү номонд бүсийн онол, Бриллюэний бүс, эффектив масс, p-n шилжилтийн физик, Больцманы кинетик тэгшитгэл, фото-эффект зэрэг сэдвийг хөндсөнөөс гадна, Ферми-Диракийн хуваарилагдах функц, Пуассоны интегралыг хэрэглэх зэрэг математикийн аргуудыг тусгажээ.

22.379я7

Ш 63

/БУУТ-12, ГНОФ-15/

ЭШФ Т-23260-23262

## ГЕОЛОГИ. ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

**Амарсайхан Д. Орчин үеийн газарзүйн мэдээллийн систем, тандан судлалын зарчмууд** / Ред. В.Батцэнгэл.- УБ.: Эрдэм, 2019.- 263х.- ISBN: 978-9919-22-218-5.



Энэхүү номын гол зорилго нь монгол улсад газар зүйн орон зайн мэдээллийн ашиглалт ба хэрэглээ эрс өссөнтэй уялдуулан энэ салбарын эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнүүд, их дээд сургуулийн багш нар, оюутнууд болон нийт хэрэглэгчдэд орчин үеийн газарзүйн мэдээллийн систем, тандан судлалын үндсэн зарчмууд, тэдгээрийн түүхэн хөгжлийн үе шатууд, мэдээллийн сангийн дизайн ба загварчлал, эх мэдээг тоон хэлбэрт хөрвүүлэх аргууд зайнаас тандсан олон эх сурвалжийн мэдээг боловсруулах стандарт болон автомат тайлалын өндөр түвшингийн аргууд, газарзүйн мэдээллийн систем ба зайнаас тандан судлах аргуудыг сэдэвчилсэн судалгаанд хэрхэн ашиглах зарчмын талаар үндсэн мэдлэг олгоход оршино.

26.82

A 516

/БУУТ-7/

ЭШФ Т-23056-23058

**Монгол орны газарзүй-геоэкологийн асуудал №40** = Geographical-Geoeological issues of mongolia / Нарийн бичгийн дарга А.Хауланбек; Ерөн. эрхл. Д.Баттогтох.- УБ., 2019.- 407х.



Энэхүү бүтээлээр манай улсын тэргүүлэх эрдэмтэн, профессор болон залуу судлаачдын Монгол улсад хэрэгжүүлж буй "Газарзүй, Орчин судлал, Экологийн чиглэлийн хэрэглээний судалгаа"-ны үр дүн болон байгалийн нөөцийн хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбоотой инноваци, технологийн судалгааны үр дүн зэрэг шинжлэх ухааны шинэ мэдлэг бүхий 36 өгүүллийг хүргэж байна.

26.89(1)я5

M 692

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23195-23197

**Жамсрандорж Г. Монгол орны ураны ордууд: Төрийн өмчит "Мон-Атом" ХХК-ийн 10 жилийн ойд зориулав** / Хян. Д.Алтанхуяг; Техник ред. А.Алтанхундага, С.Халиунаа, Ч.Ганзүрх, З.Дамдинсүрэн, Д.Сугарсүрэн; Зур. Б.Дөлгөөнмөрөн, Ч.Өсөхжаргал, Ч.Энхтөвшин; Эх бэлт. Б.Сүндэрьяа, Г.Энхдэлгэр.- УБ., 2019.- 172х.- ISBN: 978-9919-22-495-0.



Уг номоос Та бүхэн Монгол оронд хийгдсэн ураны геологи, хайгуулын ажлын судалгааны түүх, тэдгээрийн үр дүнд өнөө цагт нөөц нь тогтоогоод байгаа орд газруудын тухай мэдлэг болоод олон нийтэд төдийлөн дэлгэгдээгүй нууцалж байсан зарим мэдээллийг авах юм. Энэхүү бүтээл нь цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн салбарт


судалгаа хийж буй эрдэмтэн судлаачид, ажилтан, албан хаагч болоод энэ чиглэлээр сурч буй оюутан залуучуудын чухал гарын авлага, ширээний ном болох ажээ.

26.34(1)

Ж 235

ЭШФ Т-23203-23204

**Ховд аймгийн атлас** / Ред.С.Шийрэв-Адъяа, Ч.Лхагвасүрэн, Ж.Оюунгэрэл, Б.Сайнбуян; Зөвл. Д.Доржготов, Г.Нямдаваа.- Ховд, 2019.- 209х.- ISBN: 978-99973-45-06-6.



Ховд Их сургуулийн эрдэмтэн багш нар Шинжлэх ухааны академийн судлаачидтай хамтран “Ховд аймгийн Атлас” бүтээл туурвисан байна. Тус бүтээлд Ховд аймгийн нийгэм, эдийн засгийн салбарын хамгийн сүүлийн үеийн статистик мэдээллийг газар зүйн мэдээллийн систем ашиглан газрын зурагт тусгасны зэрэгцээ 102 эрдэмтэн, судлаачийн олон жилийн судалгааны үр дүнг нэгтгэн оруулжээ.

26.89(1-M16)я6

Х 403

ЭШФ Т-23241

### **БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН**

Ижевский С.С., Гулин В.В. **Ургамал хамгаалах биологийн аргын толь**: Словарь по биологической защите растений / Орч. Ч.Чулуунжав, Н.Энхболд; Хян. Ч.Авдай.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 184х.- ISBN: 978-9919-22-267-3.



Энэхүү толь бичигт хөнөөлт организмтай ургамалтай тэмцэх биологийн арга зүйн талаар гадаад дотоодын ном зохиолыг судлан шинжилсний үндсэн дээр ургамлын биологийн хамгаалалтын талаарх нэр томъёог оруулсны дээр ойлголт бүрийн ард тохирох англи хувилбарыг оруулж өгчээ.

28.5я2


И 311

/БУУТ-2/

ЭШФ Б-29520-29522

### **ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ**

Мягмарсүрэн Б., Дамдинсүрэн Л. **Амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн биохимийн үндэс** / Хян. Л.Дамдинсүрэн.- УБ.: Алмаз пресс, 2019.- 143х.- ISBN: 978-99978-0-187-6.



Сүүлийн үед зарим төрлийн түүхий эдийг ашиггүй өөрчлөлтөөс хамгаалах, технологийн явцад болон хадгалалтын үеийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор олон төрлийн бодис ашиглаж байна. Иймд эдгээр нэмэлт бодисууд бүхий хүнс үйлдвэрлэх, түүхий эдэд хүйтний болон дулааны боловсруулалт хийх, давслах, хатаах, химийн хамгаалах үйлчилгээтэй бодисуудыг хэрэглэх явцад гарах биохимийн хувирлуудыг судалж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг үр дүнтэйгээр зохицуулж сурах нь өнөөгийн мэргэжилтнүүдийн үүрэг юм. Тус бүтээлд амьтны эдийн биохими, мах болон амьтны гаралтай зарим түүхий эд, бүтээгдэхүүний биохими, махны шинж чанар, боловсруулсан махны биохимийн тухай үндсэн сэдвүүдийг тусгасан болно.

36.81

М 985

/БУУТ-7/

ЭШФ Т-23062-23064

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

**Монголын хөрс судлал: 2018 №03 = Mongolian journal of soil science** / Ред. О.Батхишиг.- УБ.: Удам соёл, 2018.- 176х.- (Хөрс Судлалын Холбоо).- ISSN 2522-1604.



Монголын Хөрс судлалын холбооноос эрхлэн гаргадаг судалгааны сэтгүүлийн энэ удаагийн дугаарт монгол орны зарим хэсэг газрын хөрсний шинж чанар, органик нүүрстөрөгчийн өөрчлөлт, ойн хөрсний чийг, хээрийн бүсийн хөрс, хөрсний бохирдол, хүрэн болон говийн хөрсний тухай судалгааны 20 гаруй өгүүлүүд оржээ.

40.3(1)

М 692

/БУУТ-3/

ЭШФ Т-23156-23157

**Бүүвэй Ч. Халиун буга гаршуулах, эвэр боловсруулах арга технологи** / Хян. Б.Доржготов.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 234х.- ISBN: 978-9919-21-715-0. Халиун бугыг цаг бусын аюулаас урьдчилан сэргийлж хамгаалах, гаршуулан тэжээх арга, бугын ясан болон цусан эвэр ямар хугацаанд унаж ургадаг, эврийн бүтэц-физик химийн шинж чанарыг тодорхойлж, хэзээ тайрч авч ямар аргаар боловсруулж экспортод гаргаж ашиг олох тухай дэлгэрэнгүйгээр энэ ном нь эрдэмтэн мэргэд, мэргэжлийн хүмүүс, амьтан сонирхогч, оюутан нарт гарын авлага болох ажээ.

46.3

Б 905

/БУУТ-4/

ЭШФ Т-23150-23152



## АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН

**Баярхүү Б. Шүүхийн сэтгэц эмгэг судлал** / Ред. Д.Лянхуа. – УБ.: Бэмби сан, 2019.- 228х.- ISBN: 978-99978-1-792-1.

Бие хүний сэтгэл зүй, сэтгэцийн эмгэгүүд, физиологийн ба биеийн хүчин зүйлстэй холбоотой эмгэгүүдийн талаар өгүүлэх энэ ном нь анагаах ухааны болон хуулийн салбарын оюутан, эмч, багш, хуулийн байгууллагын мэргэжилтэн, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, хуульч, өмгөөлөгч нарт зориулагджээ.

58+67.5

Б 381


/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-23144-231468



**Монгол эмийн судлал** / Эрхл. Баян; Хөрв. Г.Гомбожав; Хян. Х.Туул.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 480х.- ISBN: 978-99978-4-397-5

Эмч, эмнэлгийн ажилтан, судлаач, суралцагсад, эмийн ургамал борлуулагч болон эмийн ургамал хэрэглэдэг хэн бүхэнд зориулагдсан уг бүтээлд эмт бодисыг таньж мэдэх тухай мөн ургамлын ургах орчин, эмт бодисын зураг,





уламжлалт хэрэглээ, амт, чанар, чадлын талаар тодорхой бичсэнээс гадна эм тус бүрийн нэршлийг нь монгол, түвд, латин, англи, орос, хятад хэлээр галиглажээ.

52.81(1)

М 692

/БУУТ-5/

ЭШФ Т-23059-23061

### НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Батхишиг А. **Нийгмийн ажил:** Хамгаалах хүчин зүйлс / Ред. Ш.Оюунханд, Т.Бүрэнжаргал.- УБ.: Сэлэнгэ пресс, 2019.- 106х.- (МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхим).- ISBN: 978-99978-68-53-4.



Энэхүү бүтээлд нийгмийн ажил мэргэжил ба нийгмийн ажлын тухай олон улсын хэд хэдэн тодорхойлолт, монголын нийгмийн ажлын онцлог, хөгжил төлөвшил, хамгаалах хүчин зүйлсийг хүүхэд хамгаалалын судалгаа, практикт хэрхэн нэвтрүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаанд хамгаалах хүчин зүйлсийг хэрхэн анхаарч хэрэгжүүлж буй жишээг тус тус тусгажээ.

60.56

Б 342

/НХУУТ-7/

ЭШФ Б-29523-29525

**Нийгмийн ажлын үйлчилгээ ба сэтгэлзүйн тулгамдсан асуудлууд:** Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага / А.Батхишиг, Б.Бат-Өлзий, М.Нямдорж, В.Баярмаа; Ред. О.Алтансүх, С.Болорцэцэг; Эмхт. Г.Ойнбаяр, Г.Бадамренчин, Г.Ундрам.- УБ., 2018.- 127х.- (Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар-Сургалт судалгаа мэдээллийн төв).



Нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өнөөгийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, гэр бүлийн гишүүд ялангуяа хүүхдийг сэтгэцийн эмгэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх асуудалд эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэхэд тус гарын авлага чухал хувь нэмэр оруулах болно.

60.56+88.8

Н 587

ЭШФ Т-23244

**Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх гарын авлага:** Нийгмийн халамжийн сангийн ажилтнуудад зориулав / С.Витте, Д.Бурнетте, М.Престон ба бус.; Хян. Л.Мөнхзул, Ю.Отгонбилэг, Д.Гэрэлтуяа, Д.Чинмандах; Зөвл. М.Сугармаа, С.Хандмаа, О.Саранчулуун, Б.Ариунсанаа, Г.Золжаргалан, Т.Аира, С.Алтангэрэл.- УБ., 2017.- 191х.



Энэхүү бүтээл нь нийгмийн халамжийн салбарын ажилтнууд, нийгмийн ажилтнууд, төрийн болон төрийн бус байгууллагуудад олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ашиглах хэрэгцээтэй гарын авлага юм.

60.54

О-295

ЭШФ Т-23245

Солонго А. ба бус. **Хүний хөгжил:** Ерөнхий суурь боловсрол эзэмшихэд зориулсан их сургуулийн сурах бичиг / Б.Энхцэцэг, Ц.Болормаа; Ред. Б.Бадамханд; Диз. Т.Тэмүжин.- УБ.: МУИС пресс, 2020.- 200х.- ISBN: 978-9919-504-07-6.



Уг сурах бичигт хүний хөгжлийн ойлголт, үзэл баримтлал нь эдийн засаг, нийгэм, улс төрийн хөгжлийн бодлогын онол аргачлал болтлоо хөгжсөөр байна. Энэхүү сурах бичигт хүний хөгжлийн тухай ойлголт, ухагдахуун, үзэл баримтлал, тогвортой хөгжлийн бодлого зохицуулалт, хөгжлийн асуудлыг тусгасан байна.

60.56я73

С 555

/НХУУТ-27, ГНОФ-70/

ЭШФ Т-23227-23229

## ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Баасансүх Я. **Увс аймгийн Зүүнхангай сумын Зураагийн хошууны хадан дахь зураг:** Хайрт ээж П.Янжмаа, аав Ван Жэн Шу нарынхаа гэгээн дурсгалд зориулав / Хян. Д.Энхнаран; Хэвл. Ц.Ганболд.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 23х.



Монголын түүх, соёл, ахуй, урлагт хас тэмдэг хэрхэн дэлгэрч түгэн тархсаныг эртний судлалын олдвор, түүхийн эх сурвалж, судалгааны бүтээл, эд өлгийн зүйлд тулгуурлан өгүүлсэн энэхүү товхимолыг оюутан суралцагсад, нийт сонирхогч уншигчдад зориулжээ.

63.4(1-M15)

Б 109

ЭШФ Б-29630-29631

Дорж Д. **Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл: 2 боть** / Эрхл. Д.Цэвээндорж, Б.Цогтбаатар; Эмхт. Д.Одсүрэн, М.Адьяасүрэн; Эх бэлт. Г.Ангарагдөлгөөн.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи - Археологийн хүрээлэн).



Академиц Д.Дорж хуучнаар ЗСБНХУ-д археологийн мэргэжил эзэмшсэн Монголын хоёр дахь мэргэжилтэн ажээ. Тэрээр Монголын хүй нэгдлийн үеийн археологийн дурсгалууд, тэр дундаа Монголын чулуун зэвсгийн үе, хадны зургийн чиглэлээр дагнан судалгаа явуулж, анхны нэг сэдэвт судалгааны бүтээл туурвисан төдийгүй олон тооны өгүүлэл, илтгэл бичсэн нь одоо ч эрдэм шинжилгээний үнэ цэнээ алдаагүй, орчин үеийн судалгаа шинжилгээний үндэс суурь болсоор байна. Тус эмхэтгэлд эрдэмтний “Каменные век Монголии” докторын зэрэг хамгаалсан бүтээлийн хураангуй, Монголын чулуун зэвсгийн үе, хадны зураг, эртний иргэншлийн түүхийн асуудлаар бичсэн эрдэм шинжилгээний 30 гаруй өгүүлэл, илтгэлийг нэгтгэн оруулжээ.



63.4(1)

Д 542


**Б.1: Өгүүлэл, илтгэл.- 293х.- ISBN: 9919-9538-1-4; 978-9919-9538-1-2.**

ЭШФ Т-23251-23252

**Б. 2: Нэг сэдэвт бүтээлүүд.- 544х.- ISBN: 9919-9538-2-2; 978-9919-9538-2-9.**

ЭШФ Т-23253-23254

Дуламжав С. **Халхын сайн ноён, Түшээт хан аймгийн зарим хошуудын хийдийн түүх:** Хайрт ах С.Рагчаасүрэнгийн гэгээн дурсгалд зориулав / Ред. Б.Ичинхорлоо; Хэвл. эх бэлт. Ч.Самбууням; Хавтасны диз. Ч.Амарзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 135х.- ISBN: 978-9919-21-956-7.



Уг номонд Халхын Сайн ноён хан амйгийн Илдэн бэйлийн хошуу, Үйзэн гүний хошуу, Түмэнхэн сайн ноёны хошуу, Очирбат түшээт ханы хошууны хүрээ, хийдүүд мөн эдгээр хошуудын хийдээс тодрон гарсан хутагт хувилгаад, зарим нэг эрдэмтэн лам нар болоод нутаг усандаа хүндлэгдэж, шүтэгдсэн лам нарын тухай өгүүлсэн болно.

63.3(1)

Д 644

ЭШФ Т-23257-23259

**1755-1758 оны манжийн эсрэг монголчуудын зэвсэгт тэмцлийн түүхийн асуудал:** Илтгэлүүдийн эмхэтгэл / Эрхл. На.Сүхбаатар; Хавт. диз. А.Нямлхагва; Хэвл. эх бэлт. Т.Энхтунгалаг.- УБ.: Соёмбо принтинг, 2019. – 120х.- ISBN: 978-9919-22-188-1.



Манжийн эсрэг Монголчуудын зэвсэгт тэмцлийн түүхэнд холбогдох манж, хятад, орос хэлээрх сурвалж, баримтууд сүүлийн жилүүдэд шинээр нилээдгүй илрэн гарч байгаа нь судлаачдын сонирхлыг татаж, энэ чиглэлийн судалгаа шинжилгээ эрчимтэй хийгдэх болсон ажээ. Үүний нэг нь 2018 оны 12-р сард “1755-1758 оны Манжийн эсрэг Монголчуудын зэвсэгт тэмцлийн түүхийн асуудал” сэдэвт их семинар зохион байгуулагдаж, тус семинарт хэлэлцүүлсэн доктор На.Сүхбаатар (МУБИС), доктор О.Оюунжаргал (МУИС), доктор Н.Баярцэцэг (МУБИС), докторант Ц.Жамбалдорж (Өвөр монголын Их сургууль) нарын илтгэлүүдийг бүрэн эхээр нь толилуулж байна.

63.3(1)5

М 99

/НХУУТ-3/

ЭШФ Б-29601-29602

**Тэргүүн сайд, Түшээт засаг, Хошой чин ван Гадинбалын Чагдаржав-150 жил:** Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.- УБ., 2019.- 72х.- ISBN: 978-9919-228040.



Манж Чин улсын дарлалаас ангижирч, тусгаар улсаа байгуулахаар эвлэлдэн нэгдсэн Монголын ихэс дээдэс, хутагт хувилгаад 1911 оны намар Халхын Хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн захиран шийтгэх газар буюу Түр засгийн газар байгуулж даргаар нь Түшээ гүн Г.Чагдаржавыг томилсон байна. Тэрээр Монголын тусгаар тогтнолыг сэргээж, улс орныхоо нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан хүний нэг, Чингис хааны алтан ургийн язгууртан Монгол улсын сангийн яамны анхны сайд ажээ. Тус эмхэтгэлд судлаачид түүний үйл хэргийн талаар судлан шинжилж, хэлэлцсэн илтгэлүүд оржээ.

63.3(1)-8

Т 923

ЭШФ Б-29625-29629



Тимковский Е. **1820-21 оны Монгол**: Гурван дэвтэр аян замын тэмдэглэл / Орч. Ж.Нэргүй.- УБ.: Арилдал, 2019.- 525х.- ISBN: 978-9919-22-014-3.


Тимковский 1820-21 онд Монголын нутгаар дамжин Хятад руу очих мөн буцах замдаа Монголын тал нутаг, ард олны амьдрал зан заншил, түүх дурсгал, шашин соёлын тухай энэхүү бүтээлдээ ихэд энгийн ойлгомжтой хэллэгээр бичсэн байна. Түүнчлэн Монголтой салшгүй холбоотой Зүүн гар, Түрэгстан, Түвдийн түүх, аж ахуйн талаар өгүүлэхийн зэрэгцээ тэрээр Гэсэрийн туужийн тухай анх удаа орос хэл дээр бичиглэн үлдээсэн эрдэмтэн ажээ. Энэ бүтээл нь 1824 онд анх орос хэл дээр хэвлэгдсэн даруйдаа гадны нилээд хэдэн хэл дээр орчуулагдан гарч байсан бөгөөд орчуулагч, яруу найрагч Ж.Нэргүй нь анхны эхээс нь монгол хэл дээр хураангуйлан орчуулж, 3 дэвтэр бүтээлийг нэг хэвлэлд багтаан анх удаа монгол уншигчдад хүргэж байна.

63.3(1)

Т 384

/НХУУТ-4/

ЭШФ Б-29538-29540



Тадао Ү. **Могол угсаатныг сурвалжилсан нь** = Exploration to the Moghols in Afghanistan: Дотны анд Ямасаки Тадашигийн гэгээн дурсгалд зориулав / Ред. Ш.Чоймаа; Орч. П.Наранбаяр.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо Принтинг, 2019.- 140х.- (Monumenta Mongolica).- ISBN: 978-99962-885-0-1.

Тус бүтээлийг МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн "Монгол судлалын дурсгал" цувралд багтаан хэвлүүлжээ. Уншигч та дундад эртний могол хэлээр ярилцагч могол хүмүүс Монголын эзэнт гүрний түүхийн улбаа болон Афганистаны хязгаар нутагт үлдэн хоцорсныг япон эрдэмтний тэмдэглэн үлдээсэн сонирхолтой баримтыг энэхүү номноос унших болно. Дэлхийгээр тархан суурьшсан монголчуудын голомт нутаг болох өнөөгийн Монгол Улс нь монгол үндэстний зөөлөн хүчний төв болох ёстойг тус бүтээлд тусгасан ажээ.

63.5(1)

Т 16

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23079-23081



Хидэхиро О. **Дэлхийн түүх мэндэлсэн нь**: The Birth of the World History / Орч. П.Наранбаяр; Ред. Т.Мөнхцэцэг.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 176х.- (Monumenta Mongolica).- ISBN: 978-99962-885-4-8.

Дэлхийн түүх мэндэлсэн нь" ном нь эдүгээгээс 20 жилийн өмнө 1992 онд Японд хэвлэгдсэн байна. Нэрт зохиогч Окада Хидэхиро нь тус бүтээлдээ XIII зууны Монголын эзэнт гүрнээс дэлхийн түүх жинхэнэ утгаараа эхэлсэн гэсэн санааг судалгааны ертөнцөд дэвшүүлжээ. Уншигч та уг бүтээлээс чухам яагаад дэлхийн түүх Монголын эзэнт гүрнээс эхтэй гэж үзсэнийг ойлгож авах бөгөөд XIII зууны эхэнд Чингис хааны байгуулсан эзэнт улс түүний ач нарын үед зүүн талдаа Өмнөд Хятадын тэнгисээс өнөөгийн Ираны өндөрлөг хүрсэн өргөн уудам газар нутгийг нэг үндэстний захиргаанд оруулснаар Монголын эзэнт гүрэн түүхэнд анх Ази, Европыг шууд холбож, Евразийн эх газрын өрнө дорны харилцааг идэвхижүүлэн өргөжүүлсэн байна. Улмаар XV зуунд Европын далайн эрин үе эхлэхэд угтаа Монголын эзэнт гүрэн нөлөөлсөн ажээ.

63.3(0)

Х 347

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23082-23084



Хидэхиро О. **Энх-Амгалан хааны захидлууд** / Орч. П.Наранбаяр; Ред. Т.Мөнхцэцэг; Эрхл. Д.Заяабаатар.- 3 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 176х.- (Monumenta Mongolica).- ISBN: 978-99978-2-492-9.



МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг "Monumenta Mongolica" цувралын хүрээнд Японы нэрт эрдэмтэн, дорно дахин судлаач Окада Хидэхиро-гийн "Энх-Амгалан хааны захидлууд" хэмээх судалгааны бүтээл доктор П.Наранбаярын орчуулгаар та бүхэнд хүрч байна. Тус бүтээлд Энх-Амгалан хаан Галдан Бошигтыг дарахаар хийсэн 3 аян дайны үеэр өөрийн хайртай хоёр дахь хөвүүн Юньрөн хунтайжид илгээж байсан захидлууд оржээ. Эл захидлуудаас Энх-Амгалан хааны бодол санаа, зан араншин, Манжийн цэрэг зэвсэг хийгээд тухайн үеийн монголчуудын аж байдал, Монголын байгаль, уур амьсгал, түүнчлэн өөрийг нь монголчууд хэрхэн хүлээж авч байгаа зэрэг тэр цаг үеийн нөхцөл байдлыг тэмдэглэн үлдээсэн түүхийн чухал мэдээ баримтыг үзэх боломжтой юм.

63.3(5)

X 347

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23085-23087

**Марко Пологийн аялал** = I Viaggi Di Messer Marco Polo: Венецийн Рамузиогийн 1559 оны хувилбар / Орч. Г.Бат-Учрал, Элизабетта Рагагнин, Самүэла Симион; Ред. Ж.Ганбаатар, Ё.Мөнхбат; Эрхл. Д.Заяабаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 287х.- (Monumenta Mongolica).- ISBN: 978-99978-58-99-3.



Энэ цувралын гол зорилго нь харь хэл дээр байгаа Монголын түүхтэй холбоотой сурвалжуудыг тухайн эх хэлээс нь мэргэжлийн орчуулагчид хөрвүүлэн судлаачид болон нийт уншигчдад хүргэх юм. МУИС-ийн Европ судлалын тэнхимийн багш Г.Бат-Учрал, Бүгд Найрамдах Итали Улсын Венецийн Ка Фоскари их сургуулийн профессор, монголч эрдэмтэн Элизабетта Рагагнин, Марко Поло судлаач Самүэла Симион нар "Марко Пологийн аялал" хэмээх сурвалжийг эртний итали хэлнээс орчуулж, тайлбарын хамт уншигч та бүхэнд өргөн барьж байна. Учир нь зарим гадаад эх сурвалжууд зайлшгүй тухайн хэлнээс орчуулах шаардлага тулгардаг тул энэхүү эх сурвалжуудыг орчуулж нэлээд бодитой тайлбарын хамт хүргэхийг зорилоо.

63.3(0)+26.8г

M 265

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23088-23090

**Монголын найман богд**: Түүхийн шастир / Эрхл. Д.Гүн-Үйлс; Эмхт. Л.Хүрэлбаатар, Г.Жамсранжав.- УБ., 2019.- 460х.- ISBN: 978-99962-60-42-1.



Бүтээлийн Тэргүүн бөлөгт Монголын шарын шашны анхны тэргүүн, соёлын зүтгэлтэн, Өндөр гэгээн Занабазар буюу Жавзандамбалувсандамбийжанцан, Дэд бөлөгт хоёрдугаар Богд Лувсандамбийдонмиг, Гутгаар бөлөгт гуравдугаар Богд Ишдамбийням, Дөтгөөр бөлөгт дөрөвдүгээр Богд Жавзанлуvsантүвдэнванчигжигмэджамц, Тавдугаар бөлөгт тавдугаар Богд Цүлтэмжигмэд, Зургаадугаар бөлөгт зургаадугаар Богд Лувсанбалдандамбийжанцан, Долоодугаар бөлөгт Богд Агваанчойжинванчигпэрэнлэйжамц, Наймдугаар бөлөгт наймдугаар Богд

Жавзанагваанлуvsанчойжинямданзанванчигбалсамбуу нарын намтар цадиг, сургаал айлдварууд нь тус тус оржээ.

63.3(1)

М 692

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Т-23091-23093

Түмэн Д. **Монголын антропологийн судалгаа**: Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган - УБ., 2019.- (МУИС-ийн профессорын эрдмийн өв).- ISBN: 978-99978-58-90-0.



Энэхүү судалгааны ажилд Монгол нутаг дахь эртний нүүдэлчид болон монгол угсаатны удам, угсаа гарвалын асуудал болон түүнийг эртний хүн судлал, угсаатны антропологи, молекул антропологийн үүднээс авч үзсэн бөгөөд судалгааны үр дүнд Монголын орчин үеийн хүн ам, угсаатан хийгээд Азийн монгол төрхтний антропологи бүтэц, тэдгээрийн гарал үүсэл, удам угсааны холбооны асуудлыг угсаатны антропологийн үүднээс нэгтгэсэн цогц агуулгыг багтаажээ.

63.5(1)+28.71(1)

Т 784

**Б.1:** / Эрхл. Д.Заяабаатар; Эмхт. Г.Анхсанаа, С.Болормаа, Ч.Ванчигдаш.- 464х.

/НХУУТ-7/


ЭШФ Т-23096-23098

**Б.2:** /Эрхл. Д.Заяабаатар; Эмхт. Д.Мандах, Э.Мижиддорж, Д.Хатанбаатар.- 464х.

/НХУУТ-7/

ЭШФ Т-23099-23101

Тунгалаг Б. **Монгол Зөвлөлтийн эрэлхэг дайчид 1939 оны Халхын голд Японы түрэмгийлэгчидтэй баатарлагаар тулалдаж ялалт байгуулсан тухай өгүүлсэн агуулгын товчоон** / Хян. Б.Ичинхорлоо, С.Батмөнх.- УБ.: Арвайбархан, 2019.- 160х.- ISBN: 978-9919-21-860-7.



Уг бүтээлд ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, Монгол улсын баатар, ЗХУ-ын маршал Г.К. Жуковын "Дуртгал, бодол" номын хоёр дахь хэвлэлийн I ботиос "Халхын гол дахь зарлаагүй дайн" гэсэн гарчиг бүхий долоодугаар бүлгийн монгол орчуулгыг бүрэн эхээр нь оруулсны дээр Халхын голын үйл явдалд оролцож явсан ахмад дайчин Н.М.Румянцевын 1979 онд хэвлүүлсэн "Халхын голын баатрууд ном"-д нийтэлсэн ЗХУ-ын 70 гаруй баатрын намтрыг бүрэн эхээр нь мөн тэдгээр баатруудын Халх голын байлдаанд байгуулсан баатарлаг гавьяаны тухай зохиогчийн зүгээс бичсэн нийтлэлүүдээс нь товчлон авч, монгол хэлнээ орчуулан буулгасан байна.


63.3(1)62

Т 671

/НХУУТ-3/

ЭШФ Т-23133-23134

Мөнхбаяр Х. **Монгол баяр наадам**: Түүхэн товчоон: Түүх судлал, улс төрийн хүн судлал, соёл судлалын харилцан хамааралт судалгаа.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 400х.- ISBN: 978-9919-21-812-6.



Энэхүү номын зохиолч нь олон зуун жилийн баялаг түүхтэй Монгол улсын үндэсний их баяр наадмын түүхийн 1911-2018 он хүртэл үеийг судлан нэгтгэсэн нэг сэдэвт бүтээлээ уншигч танаа толилуулж байна. Тус бүтээлд баяр наадмын түүхийг Монголын түүхийн үндсэн үечлэлийг баримтлан судалж гаргасан ч улс үндэсний баяр наадмын өөрийнх нь хөгжлийн түүхийн онцлогийг харгалзан өвөрмөц үечлэлээр хуваан авч үзсэн сонирхолтой бүтээл болсон байна.

63.5(1)

М 816

/НХУУТ-4/

ЭШФ Т-23102-23104

Пол, Энтони. **Хятад улс-Шинэ их аян:** Түүхт зам дагуух хятад улсын аугаа их өөрчлөлтийг гэрчлэн харуулсан гэрэл зургийн аялал / Орч. М.Чимэдцэе; Хян. Ван Хао.- УБ.: Адмон принт, 2019.- 392х.- ISBN: 978-99978-3-425-6.



Энэхүү ном нь БНХАУ болон гадаадын нэртэй гэрэл зурагчид, сэтгүүлчдээс бүрдсэн баг "Их аян"-ы замаар аялж, бүс нутгийн байгалийн гайхамшигт өнгө үзэмж, тэнд оршин амьдардаг хүн ардын аж амьдрал, агуу их бүтээн байгуулалт, асар их өөрчлөлт хөгжил зэргийг гэрэл зургийн хальснаа буулгаснаар тус зурагт түүхийн номыг бүтээжээ.

63.3(5Хят)я6

П 49

ЭШФ Т-23215-23216

**Эрдэнэ зуугийн намтар оршивой** / Галиглаж, тайлбар үйлдсэн Н.Хатанбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 396х.- (Түүхийн дурсгалт бичиг Б. 11).- ISSN 0540-8334.



Монгол улсын ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний уламжлалт цуврал болох "Monumenta Historica" буюу "Түүхийн дурсгалт бичгийн чуулган" сэтгүүлийн XI тусгай дугаарт "Эрдэнэ зуугийн намтар"-ын 2 хувилбарыг нийтлүүлж олны хүртээл болгож байна. Үүнд Монгол улсын Үндэсний Номын Сангийн Гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй өдгөө судлаачдын анхааралд төдий л өртөөгүй "Эрдэнэ зуу ба өндөр гэгээний намтар" хэмээх нийлмэл сурвалжийн "Эрдэнэ зуугийн намтар" хэсэг ба "Эрдэнэ зуугийн тухай" хэмээх хоёр сурвалжийг хэвлүүлжээ.

63.3(1)

Э 739

/НХУУТ-4/

ЭШФ Т-23182-23184

### **ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН**

**Аудитын олон улсын стандарт:** Аудит баталгаажуулалтын олон улсын тунхаглал 2017 / Ред. Л.Энх-Амгалан, Л.Батцэнгэл, М.Соронзонболд, Ч.Мөнхбаяр, М.Жавхлан; Орч. Л.Батцэнгэл, М.Жавхлан, Л.Бадамханд, Ч.Мөнхбаяр, Ж.Жаргалсүрэн, Б.Энхчимэг, Д.Бүнчинсүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 870х.- ISBN: 978-1-60815-318-3.



Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбоо /НБОУХ/-ны Аудит ба Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөл /АБОУСЗ/-өөс өмнө нь 2016 оны 12 сард



батлан гаргасан "Аудитын Олон Улсын Стандарт"-ыг эх хэл дээрээ орчуулан, нийтийн хүртээл болгож байсан. Энэ удаад "Аудитын тухай" хуулиар тогтоогдсон "Аудитын байгууллагыг арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах" үндсэн үүргийнхээ дагуу "АОУС-2017"-г хэвлүүлэн олны хүртээл болгож байна.

65.052ц

А 87

/НХУУТ-3, БС-5/

ЭШФ Т-23220-23221

Бадам Ү. ба бус. **Эдийн засгийн дээд математик-I**: 1-р дэвт. / Д.Энхмэнд, Г.Анхбаяр; Ред. Г.Анхбаяр.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 311х.- ISBN: 978-99978-2-331-1.



Энэхүү гарын авлагад матрицан ба шугаман алгебрийн үндсэн элементүүдийн суурь ойлголтуудыг эзэмшихийн зэрэгцээ хавтгай дээрх шулууны болон огторгуй дахь шулуун ба хавтгайн тэгшитгэл, функц түүний үндсэн шинж чанарын талаар онолын ойлголт өгөхийн сацуу тоон дараалал, функцийн хязгаар, функцийн уламжлал тэдгээрийг эдийн засагт хэрэглэсэн олон жишээ бодлого авч үзэхийн зэрэгцээ хоёр хувьсагчийн функцийн эдийн засгийн хэрэглээг тусгасан жишээ бодлогуудыг дэлгэрэнгүй оруулжээ.

65в6+22.1

Б 153

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23176-23178

Бадам Ү. ба бус. **Эдийн засгийн дээд математик-II**: 2-р дэвт. / Д.Энхмэнд, Г.Анхбаяр; Ред. Г.Анхбаяр.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 284х.- ISBN: 978-9919-22-217-8.



Энэхүү гарын авлагад матрицан ба шугаман алгебрийн үндсэн элементүүдийн суурь ойлголтуудыг эзэмшихийн зэрэгцээ хавтгай дээрх шулууны болон огторгуй дахь шулуун ба хавтгайн тэгшитгэл, функц түүний үндсэн шинж чанарын талаар онолын ойлголт өгөхийн сацуу тоон дараалал, функцийн хязгаар, функцийн уламжлал тэдгээрийг эдийн засагт хэрэглэсэн олон жишээ бодлого авч үзэхийн зэрэгцээ хоёр хувьсагчийн функцийн эдийн засгийн хэрэглээг тусгасан жишээ бодлогуудыг дэлгэрэнгүй оруулжээ.

65в6+22.1

Б 153

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23179-23181

Будням С. **XXI зууны хөгжил** / Ред. Т.Аюурсайхан.- УБ.: МУИС пресс, 2019.- 171х.- ISBN: 978-9919-22-210-9.

Уг номонд XXI зуунд шинжлэх ухаан, боловсрол, эдийн засаг, нийгмийн салбаруудад явагдах хөгжлийн талаар дэлхийд болон Монгол улсад хийгдсэн судалгааг үндэслэн зохиогч өөрийн санааг дэвшүүлжээ.

65.011

Б 695

/НХУУТ-7, БС-5/

ЭШФ Т-23170-23172





Гүрбадам Ц. **Монгол улсын үйлдвэржүүлэлтийн түүхээс дурсахуй.**- 2 дахь хэвл.- УБ.: Би Си Ай, 2019.- 403х.- ISBN: 978-99978-2-489-9.



Уг бүтээлд Монгол орныг үйлдвэржүүлэх зорилгоор тухайн цаг үед явуулж байсан бодлого, түүнийг хэрэгжүүлэх талаар аж үйлдвэрийн ажилчин, инженер, техникч, зохион байгуулагчдаас хийж бүтээсэн зүйлс, түүний үр дагавар, өрнүүлсэн санаачлага, алдаа онооны талаар дурсамж болгон үлдээжээ.


65.290(1)

Г 87.

/НХУУТ-7, ОУХНУС-5/

ЭШФ Б-29569-29571

**Дорнод нутгийн хөгжлийн төлөө:** Дурсамжийн хуудас оршвой / Эмхт. Х.Дандийжав, Р.Хорлоо; Хян. Б.Өлзийбаян.- УБ.: Арвайбархан, 2017.- 288х.



Тус бүтээлд Дорнод аймгийн МАХН-ын /МАН/ хорооны нэгдүгээр бичгийн даргаар ажиллаж байсан Мөнхийн Эрдэнийн Дорнод нутагт ажиллаж, амьдарч, Дорнод тал нутгийн хөгжлийн төлөө мэдлэг, хүч хөдөлмөрөө зориулж явсан салбар бүрийн шилдэг ажилтнуудын дурсамжийг хамтатгажээ. Үүний хамтаар тухайн цаг үед орон нутагт хэрхэн ажиллаж байсан тухай, ололт амжилт, алдаа оноо, наргиан хөгжөөнтэй дурсамжаас толилуулсан байна.

65.28(1-M7)

Д 548

ЭШФ Т-23205-23206

Мүүти Идрис. **60 минутын брэнд стратегич:** Маркетингийн мэргэжилтнүүдэд зориулсан брэндийн тухай гарын авлага / Орч. Д.Баярхүү, Б.Амарсанаа; Ред. Б.Нэргүй.- УБ.: Непко, 2019.- 246х.- ISBN 978-9919-500-06-1.



Зохиогч Идрис Мүүти нь дизайнер, маркетер, зохиолч, гэрэл зурагчин, илтгэгч, хэвлэн нийтлэгч, бизнесийн стратегич, профессор, менежментийн зөвлөх хүн аж. Түүний зорилго бол дизайн сэтгэлгээний зарчмыг процессинг, брэндинг, маркетингаас эхлээд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршилтын загвар хүртэлх бизнесийн бүхий л чиглэлд нэвтрүүлэх юм. "60 минутын брэнд стратегич" хэмээх энэ номонд компаний удирдлагууд, борлуулалт маркетингийн менежрүүд, бизнесмэнүүдийн хувьд брэндтэй холбоотой бүхий л асуудлыг тусгажээ.

65.290-2

М 10

/НХУУТ-5, БС-2/

ЭШФ Т-23138-23140

Мэлоун Майкл С. **Интел бүтээгчид:** Робэрт Нойс, Гордон Мүүр, Энди Грөув нар хэрхэн дэлхийн хамгийн үнэ цэнэтэй компанийг байгуулсан бэ? / Орч. Б.Амарсанаа, А.Наранцогт, О.Дашням, Ч.Лхагвасүрэн, Ч.Болормаа.- УБ.: Нэпко, 2019.- 576х. ISBN: 978-99978-51-67-3.



Энэхүү бүтээлд инноваци, аугаа манлайлал, хувь хүний онцлог зан чанаруудын тухай өгүүлсний дээр ихэнх сэтгүүлчид бичгийн машин ашигладаг байсан үеэс эхлэн судалж, мэдээлэл бэлтгэж байсан Интел компанийн түүхийг дурджээ. Мөн Интелийн

бүтээгчид бол энэ компанийн зөвхөн өнгөрсөн цагийн аугаа түүх биш Интел компанид цаашид өөрийн ноёрхол, өөрийн соёл, өөрийн үнэт чанарыг хадгалан авч үлдэх гэж хичээж буй энэ үед түүний өмнө тулгараад байгаа хэцүү сорилтуудад бас дүн шижилгээ хийсэн байна.

65.9(7АНУ)

М 97

/НХУУТ-5, БС-2/

ЭШФ Т-23141-23143

Салливан Уильям Г. **Инженерчлэлийн эдийн засаг**=Engineering economy: Их сургуулийн үндсэн сурах бичиг / М.Викс Элин, С.Коллинг Патрик; Англи хэлнээс орч. О.Балдангомбо, Н.Чулуунбанди, Ч.Оюу, Т.Лхагвасүрэн, Ц.Ариунаа, Ц.Балжинням, Б.Өсөхбаяр, Б.Ариунзаяа; Ерөн.ред. З.Оюунцацрал, Ред. О.Балдангомбо, М.Бурмаа.- УБ.: ШУТИС-ийн хэвлэл, 2019.- 836х.- ISBN: 978-991922-164-5.



Энэхүү сурах бичиг нь бүх төрлийн инженер мэргэжлээр суралцаж буй оюутнууд суралцахуйн үр дүнд суурилан асуудлыг шийдвэрлэх инженерийн зохиомж, шийдлийн хувилбарыг судлан шинжилж, системчилсэн арга зүй, аргачлалыг хэрэглэх чадвар олгоход зориулагдсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сурах бичиг юм. Энэхүү хэвлэл нь 900 гаруй жишээ бодсон бодлогуудтай ба инженерчлэлийн суурь шалгалт хэлбэрийн асуултууд нь оюутнуудыг чухал шалгалтанд бэлтгэх, мэргэшсэн инженер, мэргэжилтэн болоход туслах ажээ.

65.05я73

С 228

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23173-23175

Сүхээ М. **Монгол улсын банкны системийн үүсэл хөгжил**: Мөнгө, зээл, санхүүжилт: Монгол улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойд зориулав / Хян. Т.Батбаяр.- УБ.: Мөнхийн Үсэг, 2019.- 324х.



Тус бүтээлд Монгол улсад шинэ эдийн засгийг цогцлоон байгуулахад үндэсний мөнгө, мөнгөн гүйлгээ хэрхэн нөлөөлж хөгжүүлсэн тухай, Монгол орны эдийн засаг нийгмийн хөгжлийн үечлэлийг тусгасан болно. Уг бүтээл нь Монгол ардын хувьсгал ялахаас өмнөх үед Монгол орны эдийн засаг ямар байсан, зах зээл дэх мөнгөний гүйлгээний тухай, Монгол банк байгуулагдаж, үндэсний мөнгөний шинэтгэл хийж, мөнгөн гүйлгээний үндсийг тавьсан тухай, Банкны систем нь эдийн засгийн ноён нуруу, түүний идэвхитэй үйл ажиллагаа үйлдвэрлэлийн үр дүн, үйлдвэрлэлийн үр ашиг, чанарыг дээшлүүлэхэд аж ахуйн механизмыг боловсронгуй болгох, аж ахуйн тооцоог тууштай нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх мөнгөн гүйлгээг оновчтой зохион байгуулах тухай гэсэн 4 бүлгээс бүрджээ.

65.262.1(1)

С 869

/НХУУТ-3, БС-3/

ЭШФ Т-23068-23069

**СТОУС-ын стандартууд-2018: А хэсэг**: Нэр томъёоны тайлбар / Ерөн. хян. Б.Болормаа; Хян. Ч.Даваасүрэн; Орч. Л.Бадамханд, Ч.Мөнхбаяр, Г.Оюунгэрэл.- 2019.- 1486х.- ISBN: 978-9919-22-194-2.



Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл нь тодорхой илэрхийлэл бүхий зарчимд үндэслэн тус бүтээлийг монгол хэл дээр орчуулан

нийтийн хүртээл болгон хэвлүүлжээ. Энэхүү бүтээлд СТОУС-ын стандартуудын текст, үүнд НББОУС-ын стандартууд, СТОУТХ-ны тайлбарууд, ТБХ-ны тайлбаруудыг Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын хамт тусгасан болно. Мөн СТОУС болон НББОУС-ын стандартуудыг агуулсан ба СТОУТХ болон ТБХ-ны тайлбарууд багтаагүй байна.

65.052ц

С 673

/НХУУТ-3, БС-5/

ЭШФ Т-23222-23223

**Уялдуулсан систем ба гаалийн тариф** / Боловс. А.Нарандарь, Д.Болоржаргал, Т.Хонхонцэцэг; Хян. Б.Батбямба.- УБ.: Засгийн газрын хэвлэх үйлдвэр, 2019.- 252х.



Монгол улсын гаалийн хэлээр нэвтэрдэг өргөн хэрэглээний 1700 барааны нэрийг Монгол хэлний цагаан толгойн үсгийн дарааллын дагуу жагсааж тухайн барааны ангилалын кодыг мөрийн түвшинд гарган ангилсны дээр ДГБ-ын хамгийн их борлуулалттай хэвлэл болох The Alphabetical Index - HS-г үндэслэн Монгол улсын гаалийн хилээр нэвтэрдэг өргөн хэрэглээний 2200 барааг англи нэрээр жагсааж, уялдуулсан системийн зүйл, мөрийн түвшинд ангилж мөн Монгол улсад мөрдөгдөж буй импортын болон экспортын Гаалийн татвар, Онцгой албан татвар, Автобензин, дизелийн түлшний албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Тусгай татварын тарифын хувь хэмжээг (2019 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар) Уялдуулсан системийн зүйлийн түвшинд харгалзуулан оруулсан болно.

65.428

У 708

/НХУУТ-7, БС-10/

ЭШФ Т-23185-23187

Цэндсүрэн Д., Батнасан Н. **Гаалийн эрсдэлийн удирдлага**: Онол, практикийн асуудал / Хян. Р.Энхбат; Эх бэлт. Б.Нямдорж.- УБ.: Эдмаркет, 2019.- 157х.



Тус бүтээлд эрсдэлийн удирдлагын онол арга зүй, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх практик зөвлөмж, дэлхийн зарим улс орнуудын гаалийн байгууллагаас эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж буй туршлага, монгол улсын гаалийн байгууллагын өнөөгийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, мэдээллийн технологийн нөхцөл байдлын талаар тусгажээ. Энэхүү номыг гадаад худалдааны чиглэлийн судлаачид, оюутан, төрийн байгууллага, гадаад худалдаанд оролцогч гишүүдэд зориулав.

65.428

Ц 956

/НХУУТ-7, ГНОФ-10, БС-30/

ЭШФ Т-23198-23200

## УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

**Ардчиллын замнал: Алдаа-оноо, сургамж-сорилт: 5 боть.-** УБ.: Мөнхийн үсэг, 2019.

Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойн хүрээнд ардчиллын түүхэн замналыг эмхэтгэсэн цуврал 5 боть бүтээлийг уншигч та бүхэнд толилуулж байна.

66.63(1)

A 728

**Б.1:** Түүхэн товчоон:1989-2000 он: Т.Лхагваа. **Ардчилсан нам ардчиллын төлөө тэмцэлд** / Ерөн. ред. Б.Дэлгэрмаа; Судлаач Г.Анхтуяа, Б.Болд; Зур. Т.Энхболд, Г.Эрдэнэбаяр.- 427х.- ISBN: 978-9919-22-209-3.

Ардчилал, эрх чөлөөний төлөө амь, амьдралаараа дэнчин тавин тэмцэж явсан журмын нөхөд болон Санжаасүрэнгийн Зоригийн гэгээн дурсгалд зориулжээ. Бүтээлд Ардчилсан нам нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, үндэсний хэмжээний улс төрийн хүч болон төлөвшсөн түүхэн үйл явцыг бүхэлд нь авч үзэн, ардчилсан шинэ монгол орныг цогцлоох үйл явц, их өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд ардчилсан намын оруулсан хувь нэмэр, байр суурь, ардчилсан намын үүсэл хөгжил, төлөвшлийн тухай түүхэн товчоо, он цагийн хэлхээсийг тэрлэн "Ардчилсан хувьсгал"-ын түүхт 30 жилийн ойн хүрээнд эмхэтгэн хэвлүүлж уншигч та бүхэнд толилуулж байна.

ЭШФ Т-23209

**Б.2:** Түүхэн товчоон: 2000-2012: Ш.Батбаяр. **Ардчилал нутагших явц ба ардчилсан нам** / Ерөн. ред. Т.Лхагваа; Хян. Ш.Ороссүх; Судлаач Ц.Хурцбилэг, Ө.Цоодол, Д.Пүрвээ, Б.Энхбаяр; Эх бэлт. Г.Анхтуяа.- 312х.- ISBN: 978-9919-22-759-3.

Ардчилсан намын төр барьсан, барилцсан үеүд, тухайн үетэй хамаарал бүхий түүхэн ололт зэргээс гадна улс орны эрх ашигт үл нийцсэн, санал зөрөлдсөн, улс төрийн болон гүйцэтгэх засаглалын тогтвортой байдлыг алдагдуулсан гэхчлэн алдаа мэдгийг ч аль болохуйц үнэн мөнөөр нь бичиж үлдээжээ.

ЭШФ Т-23210

**Б.3:** Түүхэн товчоон: 2012-2019: Ш.Сүхбаатар. Ялалт, ялагдал, шинэчлэл / Эмхт. О.Наранхүү; Баримт Д.Байгальмаа.- 486х.- SBN: 978-9919-22-761-6.

2012-2019 он хүртэл 7 жилийн хугацаанд ардчилалын туулж өнгөрүүлсэн гол түүхэн үйл явдлуудыг эмхэтгэн өгүүлжээ.

ЭШФ Т-23211

**Б.4:** Түүхэн товчоон:1989-2019: Т.Лхагваа. Улаанбаатар хот болон аймаг, сумдад өрнөсөн ардчилал, ардчилсан нам, хөдөлгөөн / Ерөн. ред. Т.Лхагваа; Судлаач Ч.Ганболд, Г.Анхтуяа, Р.Цэнд-Аюуш, Н.Хашцэцэг.- 765х.- ISBN: 978-9919-22-761-6.



“Улаанбаатар хотын ардчилал, ардчилсан нам”, “Аймаг, орон нутаг дахь ардчилал, ардчилсан нам”-ын үйл ажиллагааны тухай тусгасан болно.

ЭШФ Т-23212

**Б.5:**Түүхэн товчоон:1989-2019: Аймаг сумдад өрнөсөн ардчилал, ардчилсан нам, хөдөлгөөн / Ерөн. ред. Т.Лхагваа; Судлаач Ч.Ганболд, Г.Анхтуяа, Р.Цэнд-Аюуш, Н.Хашцэцэг.- 708х.- ISBN: 978-9919-22-762-3.

Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойн хүрээнд ардчиллын түүхэн замналыг эмхэтгэсэн цуврал 5 боть бүтээлийг уншигч та бүхэнд толилуулж байна. Тус бүтээлийн тавдугаар ботид "Аймаг, орон нутаг дахь ардчилал, ардчилсан нам"-ын тухай дэлгэрэнгүй тусгажээ.

ЭШФ Т-23213

**Гурван хөршийн дундахь Монгол улс:** Монголын улс төрийн үйл явцад нөлөөлөх гадаад хүчин зүйлс: Нэг сэдэвт зохиол / И.Г.Актамов, Д.Аюуш, Д.Б.Бадараев ба бус; Орч. Д.Аюуш, Б.Санжмятав; Орч. ред. Д.Аюуш; Хэвл. ред. Д.Аюуш.- УБ.: МУИС пресс, 2019.- 152х.- ISBN: 978-5-9793-1314-6.



Эл хамтарсан нэг сэдэвт бүтээлд социализмын дараах үеийн Монголын улс төрийн үйл явцад нөлөөлж буй гадны хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийжээ. Монголын газарзүйн хөршүүд болох Орос, Хятадаас гадна түүний "гуравдахь хөрш" хэмээх Барууны орнууд ба тэдгээрийн Ази дахь холбоотнуудыг тусгайлан авч үзсэн байна. Уг номыг дорно дахиныг судлаач, түүхч, улс төр судлаач, нийгэм судлаач болон орчин үеийн олон улсын харилцааг сонирхогч мэргэжилтнүүдэд болон өргөн хүрээний уншигчдад зориулав.

66.4(1)

Г 773

/НХУУТ-7/

ЭШФ Б-29617-29619

**Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019) /** Хян. Ж.Төртогтох, С.Ганзаяа; Хавт. зур. Б.Баттөгс.- УБ.: Адмон принт, 2019.- 299х.



Энэхүү хамтын бүтээл нь “Ардчиллын бэхжилт, төрийн эрх мэдлийн институтын зарим асуудал”, “Ардчиллын институцийн хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал”, “Монгол дахь ардчиллын эдийн засаг, социал, нийгэм-сэтгэл зүйн олон талт өөрчлөлт, тулгамдсан асуудал” гэсэн үндсэн гурван бүлэг сэдвээс бүрджээ. Энэхүү тойм судалгааны хүрээнд Монголын ардчиллын хөгжил, түүний гажуудал, өнөөгийн нөхцөл байдал, нөлөөлсөн хүчин зүйлсийг төр, нийгэм эдийн засгийн харилцаан дахь шилжилт, тогтворжилтын онол, үзэл баримтлалаар гаргахыг зорьсон байна.

66.63(1)+65.9

М 692

/НХУУТ-7/

ЭШФ Т-23192-23194

Ууганбаатар Р. **Капиталист намын тунхаг:** Улсын бүх капиталыг ард түмний гарт атгуулахад энэхүү бүтээл зориулагдав / Хэвлийн эх бэлт. - 3 дахь хэвл.- УБ.: НЕФКО, 2018.- 594х.- ISBN: 978-99978-3-026-5.



Капиталист Намын Тунхаг ном нь социализмаас капитализмд шилжих явцдаа Монголчуудын гаргасан 15-н томоохон алдааг нэрлэж, эдгээр алдаанаас үүссэн өнөөгийн хууль эрхзүй, эдийн засаг, улс төр болон нийгмийн гажуудлуудыг



тайлбарлах бөгөөд системийн эдгээр 15-н алдааг хэрхэн засах арга замыг тодорхойлсон бүтээл болжээ.

66.6

У-588

/НХУУТ-4/

ЭШФ Б-29603-29605

Цанжид А. **Монголын төрт ёс** / Ред. С.Отголжий.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 272х.- ISBN: 978-9919-21-382-4.



Уг бүтээлд төр, төрт ёс хэмээх ойлголтын талаар тодорхойлолт гаргаснаас гадна төрт ёсны бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлж түүнд түшиглэн монголын төрт ёсны бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар улс төр судлал, түүхэн аргыг ашиглан дэлгэрэнгүй авч үзсэн болно.

66.1(1)

Ц 191

/НХУУТ-4, НУС-5/

ЭШФ Т-23070-23072

Үржинлхүндэв П. **Ойр дайдын оронтой түншилсэн түүхээс** / Ерөн. ред. И.Рэнчинханд.- УБ.: Сэлэнгэпресс, 2019.- 273х.- ISBN: 978-9919-22-300-7.



Тус номонд зохиолч Монгол-Солонгосын дээхэн үеийн харилцааны тухай ахмад дипломатчдаас дуулж мэдсэн, уншиж судалснаа тунгаан нягталж бичсэний дээр БНАСАУ-ын нам, төрийн зарим зүтгэлтэн болон нэгэн үед багш, шавийн харилцаатай байсан нэр бүхий буянтай хүмүүсийн талаар мөн Солонгосын үндэсний нэгдэл, хойгийн аюулгүй байдлын талаар өгүүлжээ.

66.4(1)

Ү 873

/НХУУТ-7/

ЭШФ Б-29547-29549

## **ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН**

**Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь:** Гарын авлага / Боловс. Д.Наранчимэг, З.Баярчимэг, Д.Баяраа; Хян. Д.Дуламсүрэн, Д.Цэнд-аюуш.- УБ.: Урангар пресс, 2019.- 156х.



Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, сонирхлын зөрчлийг зохицуулах шаардлага, арга механизм, зөрчлийг зохицуулахад удирдлага болон нийтийн албан тушаалтны үүрэг, тавигдах хориглолт, хязгаарлалт, байгууллагын хүлээх үүрэг, зөрчлийн мэдүүлэг, оффшорын асуудлын эрх зүйн зохицуулалт, сонирхлын зөрчлийг зохицуулж буй ОУ-ын туршлага, санаачилга, зөвлөмжүүдийг уг гарын авлагад багтсан байна.

67.408

А 944

/НХУУТ-2, ХЗС-2/

ЭШФ Т-22888-22889

**Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл** / Эмхт. Д.Цэнд-Аюуш, Л.Нарантуяа, Д.Балдандорж; Хян. З.Энхтайван; Эх бэлт. Б.Тамир.- УБ., 2016.- 508х.- (Монгол улсын авлигатай тэмцэх газар).



Тус эмхэтгэлд Авлигалын эсрэг НҮБ-ын конвенц, Авлигын эсрэг хууль ба түүнд холбогдох бусад хуулиуд, УИХ-ын болон Хууль зүйн байнгын хорооны тогтоол,

Засгийн газрын тогтоол, Авлигатай тэмцэх газрын даргын тушаалуудыг эмхэтгэн төгсгөлд нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний /2002-2017 он/ жагсаалтыг хавсаргасан байна.

67.408

A 183

/ХЗС-2/

ЭШФ Т-23266-23268

**Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн гарын авлага** / Б.Батзориг, Х.Баавгай, Ч.Алтангэрэл ба бус.- УБ., 2017.- 220х.



Энэхүү гарын авлагаас хүүхдийн эрх, хүүхэд хамгаалалтай холбоотой хууль, эрх зүйн актууд, түүнийг тодорхой тохиолдлуудад хэрхэн хэрэглэх, хуулийн салбарт хүүхдийн эрх ашгийг хэрхэн хамгаалан ажиллах, түүнчлэн боловсрол гэр бүл, иргэний болон эрүүгийн эрх зүйн салбарын талаарх хуулийг хэрэглэх процедурын талаар мэдлэг, ойлголтыг авах болно.

67.400.7я7

X 855

ЭШФ Т-23240

**Авлига, албан тушаалын гэмт хэрэг:** Хуульчдад зориулсан гарын авлага / Б.Батзориг, Ц.Цэлмэг, Г.Оюунболд ба бус.; Эмхт. Д.Цэцэгдарь; Хян. Ц.Цэлмэг.- УБ.: ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 2014.- 224х.



Энэхүү гарын авлагын зорилго нь хууль, хууль сахиулагчдын авлига, албан тушаалын гэмт хэргийн өнөөгийн байдал, шалтгаан шийдвэрлэх чадварыг нэмэгдүүлэх, зөв хандлага тогтооход оршино.

67.408я7

A-17.

/ХЗС-3/

ЭШФ Т-23230

**Буянхишиг Б. Иргэний эрх зүйн тусгай анги:** III-I дэвтэр / Хян. Ц.Амарсайхан.- 5 дахь хэвл.- УБ., 2019.- 475х.- ISBN: 978-99973-74-35-6.



Зохиогч энэхүү тав дахь удаагийн хэвлэлдээ гэрээний эрх зүйг дагнан судалж, шүүхийн практикт хийсэн судалгааны үр дүн буюу 2014 болон түүнээс өмнөх шүүхийн шийдвэрүүдийг ишлэх, жишээ тохиолдол боловсруулах замаар тусгасан бөгөөд, даатгалын гэрээ, үнэт цаасны арилжаа, өвийн гэрээ, мөн худалдааны эрх зүйн худалдааны төлөөлөл, зуучлал, фидуцын гэрээ, хамтран ажиллах гэрээ зэрэг нилээд хэд хэдэн хэлцлийн төрлүүдийг боловсронгуй болгон оруулсан байна.

67.404

B 819

/НХУУТ-3, ХЗС-25/

ЭШФ Т-23051-23052

**Гэр бүл, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл** / Эмхт. Л.Бадамцэцэг, С.Байгалмаа, Я.Цэрэнлхам, Э.Ганчимэг; Хян. Н.Өлзийхутаг, Ц.Уранчимэг.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 368х.



Энэ номонд 2016 онд батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол улсын хууль", "Хүүхдийн эрхийн тухай Монгол улсын хууль", "Хүүхэд

хамгааллын тухай Монгол улсын хууль" мөн эдгээр хуулиудтай холбогдолтой яамны сайдын тушаал, тогтоол, дагаж мөрдөх журмуудыг эмхэтгэн оруулжээ.

67.404.4(1)

Г 94

ЭШФ Т-23238

**Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн эмхэтгэл:** Албан хэрэгцээнд зориулав / Эмхт. У.Долгормаа; Хян. Н.Баярмаа. О.Сэлэнгэ.- УБ.: Сэлэнгэ пресс, 2019.- 152х.- (Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам. Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар).



Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас залуучуудаа дэмжих бодлого, зорилтын хүрээнд энэхүү эрх зүйн баримт бичгийг эмхэтгэн гаргажээ. Тус бүтээлд Залуучуудын хөгжлийг дэмжих хууль, үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, залуучуудын чадварыг үнэлэх аргачлал, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйн тайлбар зөвлөмжүүд багтсан байна.

67.400.7

3-236

ЭШФ Т-23242

Лхагвасүрэн Б. **Шинжлэн магадлах ухаан** / Хян. Б.Бат-Эрдэнэ.- УБ.: Сэлэнгэпресс, 2018.- 196х.- ISBN: 978-99978-4-639-6.



Шинжлэн магадлах ухаан гэдэг нь хүн ба юм, үзэгдлийн зүй тогтол, хэрэг зөрчлийн бүтцийн зүй тогтлын сургаалд үндэслэн шинжлэн магадлах үйл ажиллагааны онол арга зүй, эрх зүй, зохион байгуулалтын үндсийг боловсруулж, судлагдахууныг эрэмбэлэн цэгцэлдэг мэдлэгийн салбар юм. Энэ номонд шинжлэн магадлах ухааны онол, судлах зүйл, үүсэл хөгжил, эрх зүйн зохицуулалт, шинжлэн магадлах үйл ажиллагааны арга зүйн талаар өгүүлжээ.

67.408

Л 874

/НХУУТ-3, ХЗС-5/

ЭШФ Т-23168-23169

Сыроежкин К. **"Бар"-ын ав: Хятадад өрнөж буй авлигатай тэмцэх ажиллагаа** = Охота на "Тигров": Почему и как Китае борются коррупцией / Орч. Д.Зоригт; Хян. Ц.Нямдорж.- УБ.: Адмон принтинг, 2019.- 326х.- ISBN: 978-99978-3-210-8.



"Авлига болон ялзралтай тэмцэх" ажиллагаа өнөөгийн Хятадын улс төрийн бодлогын гол хандлага болж байна. Чухамхүү энэ ажиллагаа БНХАУ дахь улс төрийн үйл явцын онцлог болон хятад үндэстний шинэчлэлийн хэтийн төлвийг тодорхойлж байгаа юм. Мөн Хятадын улс төрийн хүрээн дэх тэмцэл хэрхэн газар авч, хурцдаж буйг харуулж байна. Энэ ажиллагаа яагаад "тав дахь үеийн" удирдагчдын "нэрийн хуудас" болов? үүнийг хэрхэн явуулж буй, хэмжээ далайц нь ямар байгаа? ажиллагаа ямар үр дүнд хүрсэн, энэ нь хятадын улс төрийн бодлогод хэрхэн нөлөөлж байна вэ? эдгээр асуултыг хамарсан

болно. Энэхүү номыг улс төр судлаач, олон улсын харилцаа, аюулгүй байдлын мэргэжилтнүүдэд зориулжээ.

67.408(5Хят)

С 95

ЭШФ Т-23255-23256

**Судалгааны тайлангийн эмхэтгэл: 2 боть / Хян. З.Баасанням, Ц.Шинэбаяр; Боловср. Ц.Бадам.- УБ.: Урангар пресс, 2019.- (Авлигатай Тэмцэх Газар).**



Энэхүү эмхэтгэл нь тус газраас зохион байгуулсан давтамжит судалгааны үр дүнгийн тайлангуудаас бүрдсэн бөгөөд эдгээрийг гурван боть болгон эмхэтгэжээ. Судалгааны ажлын үр дүнгийн тайлангууд нь бодлого боловсруулагчид, төрийн байгууллагын албан хаагчид, олон улсын байгууллагын ажилтнуудад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг боловсруулах, төлөвлөх, үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг хүргэх, эрдэмтэд, судлаачдад судалгаа, мэдээллийн эх сурвалж болгох зорилгоор боловсруулсан болно.

67.408(1)

С 701

**Б.1: 2008-2011 он.- 256х.- ISBN: 978-9919-22-714-2.**

/ХЗС-2/

ЭШФ Т-23269-23271

**Б.2: 2012-2015 он.- 377х.- ISBN: 978-9919-22-715-9**

/ХЗС-2/

ЭШФ Т-23272-23274



**Хүүхдийн хөдөлмөрийн холбогдолтой хууль тогтоомжийн эмхэтгэл / Ред. Б.Халиун; Эмхт. Ж.Азжаргал, М.Отгонгэрэл; Хэвлэлийн эх бэлт. Ц.Баатархүү; Хавтасны дизайныг Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 138х.**

Тус бүтээлд хөдөлмөрийн тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, бодлогын жишиг баримт бичиг, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай зөвлөмжийг бусад холбогдох хууль тогтоомжийн хамт тусгасан болно.

67.405

Х 855

ЭШФ Т-23248

**Швейцарын Холбооны Улсын олон улсын хувийн эрх зүйн тухай хууль / Орч. Б.Тамир.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 112х.- (Хувийн эрх зүйн цуврал).- ISBN: 978-9919-22-290-1.**

Швейцарын Холбооны улсын олон улсын хувийн эрх зүйн тухай хууль батлагдсан цагаасаа хойш 32 жил, хүчин төгөлдөр болсноос хойш 30 жил болж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд түүнд нэжгээд удаа нэмэлт, өөрчлөлт орсон хэдий ч уг хууль логик холбоо, хэрэглэхэд хялбар байдал,



практик ач холбогдлоо алдаагүй ажээ. Хувийн эрх зүйн цувралын энэ дугаарт тус хуулийг бүрэн эхээр нь оруулжээ.

67.412.2(4Шве)

Ш 382

/НХУУТ-7, ОУХНУС-5/

ЭШФ Б-29572-29574

### СОЁЛ. СОЁЛ СУДЛАЛ

Баатар Н. **Хүн төрөлхтөний /дэлхийн/ нүүдлийн соёл иргэншлийн төв:** Танин мэдэхүй, аялал жуулчлалын цогцолбор үзмэрийн сэдэвчилсэн төлөвлөгөө, сценари / Ред. Л.Эрдэнэбаатар.- УБ.: Адмон принт, 2019.- 100х.- ISBN: 978-9919-21-538-5.

Энэхүү гарын авлагад "Хүн төрөлхтний /Дэлхийн/ Нүүдлийн соёл иргэншлийн төв" нэртэй аялал жуулчлал, танин мэдэхүйн цогцолбор бүтээн босгох сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулсан болно. Тус сэдэвчилсэн төлөвлөгөөнөөс хэсэгчлэн авч аймаг хот, сумдад орон нутаг өөрийн хүч хөрөнгөөр тухайн газар нутаг, түүх соёлтойгоо уялдуулан эх байгаль, хот айл, монгол гэр, гал голомт гэх мэт хөшөө дурсгал, үзмэр бүтээн босгох боломж нээлттэй байна.

71.05

Б 111

ЭШФ Б-29620-29622

**Дүрс, дуу авианд шингэсэн соёлын баримтат өвийн өнөөгийн байдал:** Эрдэм шинжилгээ онол практикийн хурлын илтгэлийн эмхэтгэл / Эмхт. Д.Мэндсайхан, Б.Цогжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 108х.

Тус бүтээлд шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийн үр дүнд бүтсэн дүрс, дуу авианд шингэсэн үндэсний соёлын баримтат өвийн үүсэл хөгжил, төрөл ангилал, хадгалалт хамгаалалт, судалгаа шинжилгээний талаар мэдлэг мэдээллийг хүргэж, хойч үедээ энэ эрхэм өвийг өвлүүлэн үлдээх зорилгыг агуулсан болно.

71.0

Д 78

ЭШФ Б-29608-29610

### ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ

**Эрдэм шинжилгээний бичиг №33 (515): Эдийн засаг:** Онол, практик / Ред. Б.Алтанцэцэг.- УБ.: МУИС пресс, 2019.- 132х.- (МУИС. ШУС. Эдийн засгийн тэнхим).- ISSN 2617-247X.

Энэ удаагийн дугаарт ОУХХАБ-ын орнуудын инфляцийн хамаарал дахь бүтцийн өөрчлөлт, Монгол улсын оптималь мөнгөний бодлогын дүрэм, Монгол улсын хүн амын 2014 оны ядуурах эмзэг байдлын үнэлгээ, Монголын





хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн талын шинжилгээ, Монгол улсын мөнгөний бодлого, 2014 оны эмзэг байдлын үнэлгээ, хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлттэй холбогдолтой судалгааны өгүүлүүд оржээ.


72+65

Э-21

/ЛавФ- 841/

ЭШФ Т-23214

**Эрдэм шинжилгээний бичиг: Философи, шашин судлал № 21 (516) =** Philosophy, religious studies / Ерөн. эрхл. Б.Дагзмаа; Нарийн бичгийн дарга С.Янжинсүрэн; Гишүүд М.Гантуяа, Р.Дарьхүү, С.Лалла, Т.Мацукава, К.Телеки, М.Отгонбаяр, Г.Чулуунбаатар.- УБ.: ТОТО пресс, 2019.- 148х.



Энэхүү эрдэм шинжилгээний бичигт философи, шашин судлалын чиглэлийн 11 судалгааны өгүүлэлийг эмхтгэжээ.

72+86.2я5

Э 739

/НХУУТ-5, ЛавФ 843/

ЭШФ Т-23217-23219

## **БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН**

**Ази-Номхон далайн орнуудын их сургуулийн мобилити (UMAP) ба кредит шилжүүлэх схем (UCTS) /** Орч.эмхт. Ж.Ариунболд, Б.Батцэцэг; Хян. Г.Даваажаргал; Хэвлэлд бэлт. О.Мөнхбаясгалан.- УБ., 2019.- 23х.- ISBN: 978-9919-22-769-2.



Ази-Номхон далайн орнуудын их сургуулийн мобилити нь бүс нутгийн орнуудын их сургуулийн оюутан, багш, ажилчдын шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлэх замаар олон улсын ойлголтыг дээшлүүлэх зорилготой бөгөөд 20 улс орны гишүүнчлэлтэй, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн сайн дурын байгууллага юм. Энэ номонд АНДОИСМ-ийн оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах журам, гишүүнчлэлийн төлбөр, бүтцийн талаар өгүүлжээ.

74.58

А 341

ЭШФ Т-23158-23162

**Гэр бүлийн хөгжлийн тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам:** Эрдэм шинжилгээний бага хурал / Хян. Х.Баавгай; Хэвлэлд бэлт. Н.Оюунчимэг; Зургийг Х.Даваадорж.- УБ., 2016.- 188х.



Тус эрдэм шинжилгээний хуралд хүүхэд, гэр бүлийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг эрдэмтэд, судлаачдын 30 гаруй бүтээл тусгагджээ. Хуралд гэр бүлийн харилцааны, гэр бүлийн тогтвортой байдлын, гэр бүлийн орчин дахь хүүхдийн хөгжил, хамгаалалын тулгамдсан асуудлуудыг хамарч, хэлэлцсэн болно.

74.905

Г 94

ЭШФ Т-23246

Даваа Ж., Алтантунгалаг Ш. **Их, дээд сургууль, коллежийн багш, оюутан:** Мэргэжлийн хөгжил, ёс зүй, суралцах чадвар, дасан зохицох чадвар / Ред. Ц.Нямаа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 180х.- ISBN: 978-9919-22-488-2.



Дээд боловсролын шинэчлэлийн чухал салшгүй хэсэг бол их дээд сургууль, коллежийн багш болон оюутан суралцагчдын асуудал байдаг. Энэ номонд их дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн хөгжил, багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, оюутан хүний ёс суртахууны соёл төлөвшихөд багшийн оролцоо, багшийн сургалтын технологийн боловсрол, ур чадвар, оюутны суралцах чадвар, үнэлгээ, дасан зохицох мөн бие даан суралцах чадвар, тэдний сэтгэл ханамжийн талаар өгүүлжээ.


74.58

Д 121

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-23153-23155

Дью Жон. **Ардчилал ба боловсрол**= Democracy and education: Боловсролын философийн удиртгал / Эх хэлнээ хөрв. А.Заяадэлгэр, Д.Ундрах, Д.Алтанцэцэг, С.Эрдэмчимэг; Ред . Б.Жадамба.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 400х.- ISBN: 978-99978-2-690-9.



Энэхүү бүтээл нь ихээхэн алдартай бөгөөд боловсролын прагматик философийн суурь бүтээлүүдийн нэг юм. Номын гол санаа нь зарим философийн урсгалын санал болгож байгаа шиг боловсрол залуу үеийг ирээдүйн амьдралд бэлтгэх төдий зүйл биш, харин боловсрол өөрөө амьдрал гэж үзэх тухай бөгөөд энэ номонд дэвшүүлсэн санааг хүмүүний төрөлх араншин, үйл, мөн чанарт үндэслэн санал болгосон нь зуун дамжин яригдах сэдэв болж чаджээ.

74.03+87.3

Д 808

/НХУУТ-7/

ЭШФ Т-23165-23167

**Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь**= Mongolian-English-Russian glossary of higher education terminology / Зөвл. Д.Бадарч, Н.Бэгз, Б.Жадамба, Б.Туяа; Эмхт. Б.Лхамцэрэн.- УБ.: Содпресс, 2019.- 278х.- ISBN: 99978-61-95-7 978-99978-61-95-5.



Тус тайлбар толь нь боловсролын сургалт, судалгааны байгууллагын багш, мэргэжилтэн, суралцагч, судлаачдад зориулагдсан бөгөөд дээд боловсролын сургалтын хөтөлбөр, хөтөлбөр судлал, магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалт, багшлах болон суралцах үйл ажиллагаа, мэргэшлийн үндэсний хүрээнд холбогдох нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолтыг багтаасан болно.

74.58я2

Д 966

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23263-23265

Жин, Сато. **Топ их сургууль юугаараа топ вэ?** : University of Tokyo & Princeton / Орч. М.Ариунтуяа; Ред. О.Энхжавхлан.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 294х.- ISBN: 978-9919-21-909-3.



Хөгжлөөрөө тэргүүлэгч хоёр их гүрний шилдэг хоёр их сургуулийн төсөөтэй болон ялгаатай талыг судлан тайлбарласан уг бүтээл нь даяаршиж буй ертөнцөд дээд боловсролын талаархи ойлголт хэрхэн өөрчлөгдөж байгаа, улс орнууд дээд боловсролын салбартаа шинэчлэл хийхдээ гадны шилдэг туршлагыг унаган хөрсөндөө хэрхэн нутагшуулах тухай болон Японы топ их сургууль Америкаас хуулдаг уу гэх мэт олон сонирхолтой асуултанд энэ ном хариулт өгөх болно. Тус бүтээлийг их дээд сургуулийн багш, судлаачид, бодлого боловсруулагчдаас гадна гадаадад суралцах хүсэлтэй залуус, эцэг эхчүүдэд зориулав.

74.58

Ж 72

/НХУУТ-7/

ЭШФ Б-29541-29543

**Сурахад суралцах нь** / Редакцийн зөвл. Д.Ганзориг, Ч.Лодойравсал, П.Наранбаяр ба бус.- УБ.: Улаанбаатар пресс, 2019.- 256х.- ISBN: 978-9919-22-674-9.



Уг номоос уншигч та сурах гэж юу болох, сурах арга барилын талаар, манай улсад болоод монголчууд бидний сонирхон судалдаг Япон оронд хүнийг хэрхэн сургаж ирсэн тухай, сурахад ямар асуудлууд ба гарцууд байгаа талаар боловсрол судлаачид, энэ салбарт ажиллаж багагүй туршлага хуримтлуулсан тус клубийн гишүүд туршлага, санал бодлоо хуваалцсаныг унших болно.

74.202.5

С 747

ЭШФ Б-29611-29612

**Түвдэнгийн Гун-Аажавын Монгол Улсын Их Сургуульд суралцаж, ажилласан нэгэн жаран** / Эмхт. М.Цогбадрах; Ред. Д.Энхнаран; Дизайнер Ц.Ганболд.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 199х.- ISBN: 978-9919-22-464-6.



Түвдэнгийн Гун-Аажавын Монгол Улсын Их Сургуульд суралцаж, ажиллаж ирсэн хөдөлмөр бүтээлийн 50-н жилийн ой, түүний санаачлагаар үүсэн байгуулагдсан Биофизикийн тэнхимийн 30-н жилийн ойг тохиолдуулан гаргасан бүтээл болно. Эрхэм уншигчид, оюутан залуус, эрдэмтэн багш нар тус номоос профессор Т.Гун-Аажавын сургалт, хүмүүжил, эрдэм шинжилгээ, удирдлага зохион байгууллалтын олон талт үйл ажиллагаатай нь танилцах болно.

74.58(1)

Т 731

ЭШФ Т-23207-23208

**Хүүхэд шийдэл:** Монголын хүүхдийн хөгжил, судлалын асуудлууд-2017 / Техник. ред. Н.Заяахүү, Б.Хонгорзул.- УБ., 2017.- 337х.



Тус бүтээл нь гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр ажиллаж буй ажилтан, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, иргэний нийгмийн болон судалгаа шинжилгээний байгууллагууд олон улсын хөгжлийн түншүүд та бүхэнд хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлыг шинжлэх ухааны үндэстэй шийдэх, олон улсын нийтлэг жишиг, үндэсний өв уламжлал, онцлогийг хослуулж, бодит хэрэгцээнд суурилсан бодлого боловсруулахад суурь мэдээлэл, үнэтэй сурвалж болох ажээ.

74.200(1)+60.54

X 856

ЭШФ Т-23249

**Хүүхдийн байгууллагын үүсэл, хөгжил, шинэчлэл:** Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл.- УБ.: Битпресс, 2015.- 102х.



Монгол улсад хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойд зориулан зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд хүүхэд хамгаалалын талаархи ойлголтыг тодорхойлох, хүүхэд хамгааллын үйлчилгээний өнөөгийн байдлыг судлан шинжилгээ хийх, нийгмийн ажлыг сайжруулах чиглэлээр хэлэлцүүлсэн илтгэлүүдийг эмхэтгэжээ.

74.27(1)

X 855

ЭШФ Т-23250

**XXI зууны монгол гэр бүл:** Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл / Эмхт. Ч.Болор-Эрдэнэ; Ред. Б.Оюун-Эрдэнэ.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 232х.



Хүүхдийн хөгжлийн онол, арга зүйг боловсруулах, хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн оролцооны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, гэр бүлийн өдөр тутмын амьдралын дадал хэвшил, дэг журамд тулгуурлан хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох, санал, зөвлөмж боловсруулахад чиглэсэн салбарын судлаачдын хэлэлцүүлсэн илтгэлүүдийг энэ номноос үзэх боломжтой.

74.9(1)р

X 478

ЭШФ Т-23247

### **БИЕЙН ТАМИР. СПОРТ**

**Биеийн тамир:** Ерөнхий суурь боловсрол эзэмшихэд зориулсан их сургуулийн сурах бичиг / Д.Бат-Өлзий, Ж.Баньдхүү, Б.Болд-Эрдэнэ ба бус.; Ред. Л.Уртнасан, Д.Баасанбат, Р.Бигэрмаа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 278х.- ISBN: 978-9919-504-08-3.



Энэхүү сурах бичигт биеийн тамир спортын үндсэн ухагдахуун болон хүний

хөдөлгөөн-эрүүл мэндтэй холбоотой онолын ойлголт, манай улсад хөгжиж буй бүх төрлийн спортын үүсэл хөгжил, үндсэн техник, дүрэм, өмсгөл хэрэглэлийн талаар дэлгэрэнгүй тайлбарласан байна. Үүнд: эмчилгээний биеийн тамир, хөнгөн атлетик, иог, гимнастик, бөхийн спорт, тулааны урлаг, сэлэм, бөмбөг, бүжиг, дугуй гэх мэт биеийн тамир спортын өргөн төрлийг хамруулсан төдийгүй спортоор хичээллэх үедээ гэмтэл бэртлээс сэргийлэх, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх аргуудын талаар дурджээ.

75.1я73

Б 466

/НХУУТ-7, ГНОФ-20/

ЭШФ Т-23224-23226

Суэтин А.С. **Ур чадвараа сайжруулах арга замууд**: Шатрын багш дасгалжуулагч нарт зориулав / Орч. Ж.Лхагваа, Д.Дамдин; Хян. Ч.Баттүвшин.- УБ.: Амжа принтинг, 2019.- 174х.- ISBN: 978-9978-69-05-0.



Зохиогч энэхүү номоо тоглолтын өндөр түвшинд хүрч ирээдүйд тив, дэлхийн аваргуудын эгнээг өргөжүүлэх өсвөр, залуу шатарчдад зориулан бичжээ. Хүмүүс харилцан адилгүй зан араншинтай ч та бүхэнд өөрийн сэтгэлгээний алдаа дутагдлыг засаж залруулан шатарчин хүн оюун бодлоо зөв залж, муу зуршлаасаа хэрхэн яаж ангижрах талаар тодорхой ойлголт өгөхөд тус номын ач холбогдол оршино.

75.581

С 779

/НХУУТ-3/

ЭШФ Б-29553-29554

### НОМ, ХЭВЛЭЛИЙН АЖИЛ

Дашжав Д. **Монгол маркийг судлахуй** = Research of mongolian stamps.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 560х.- ISBN: 978-99978-69-35-7.



Энэхүү бүтээл нь он цагийн хувьд Монгол марк анх гарсан 1924 оноос эдүгээ 2018 оныг дуустал хэвлэгдэн гарсан 75 жилийн нийт маркийг сэдэвчлэн харуулж, маркийг хэн зурсан, хаана хэвлэгдсэн, тоо, ширхэг, анх гарсан үнэ одоогийн мөрдөж буй үнэ, сэдвийн доторхи сери, блок, клейнбоген (хэлхээ буюу багаа хуудас) делакс, стикер (хуулж наадаг) маркийг тусгайд нь харуулжээ.

76.19(1)

Д 394

/НХУУТ-3/

ЭШФ Т-23128-23129

### МУЗЕЙ СУДЛАЛ

**Музей судлал** / Ерөн. эрхл. Д.Сүхбаатар; Нарийн бичгийн дарга Д.Бумаа; Гишүүд З.Лонжид, Д.Цэдмаа, Ц.Цэндсүрэн, Ж.Баярсайхан, Д.Мөнхтоого; Эх бэлт. Л.Эрдэнэсүвд.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 264х.- (Монголын үндэсний музей=Studia Museologica Museum National Mongoli: Tom. XVIII-I Fasc. 1-25).- ISBN: 978-99929-1-499-8; 978-99929-1-499-1.



Монголын Үндэсний Музейгээс "Музей судлал" нэрийг дахин сэргээж, музей



судлалын онолын үзэл баримтлал, музейн түүх, цуглуулгыг судалгааны эргэлтэнд оруулж, монгол оронд музей судлалыг хөгжүүлэх зорилгоор бие даасан эрдэм шинжилгээний сэтгүүл бэлтгэн хүргэж байна. Судалгааны сэтгүүлийн энэ дугаарт музей судлаачдын музейн хөгжил, менежмент, үзмэрүүдийн судалгаа, хадгалалт хамгаалалт, музейн боловсрол гэх мэт өргөн хүрээнд хийж буй судалгааны үр дүн, туршлагыг хуваалцсан байна.

79.1я5

М 865

ЭШФ Т-23235

**Музей судлал** / Ерөн. эрхл. Д.Сүхбаатар; Нарийн бичгийн дарга Д.Бумаа; Зөвл. З.Лонжид, Д.Цэдмаа, Ц.Цэндсүрэн, Ж.Баярсайхан, Д.Мөнхтоогоо; Эх бэлт. О.Ууганбаатар, Г.Хулан; Дугаар эрхл. Д.Бумаа.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 301х.- (Монголын үндэсний музей=Studia Museologica Museum National Mongoli: Tom. XVII. Fasc. 1-34).- ISBN: 978-99929-1-499-8; 978-99929-1-499-1.



Монголын Үндэсний Музейгээс "Музей судлал" нэрийг дахин сэргээж, музей судлалын онолын үзэл баримтлал, музейн түүх, цуглуулгыг судалгааны эргэлтэнд оруулж, монгол оронд музей судлалыг хөгжүүлэх зорилгоор бие даасан эрдэм шинжилгээний сэтгүүл бэлтгэн хүргэж байна. Сэтгүүлийн энэ дугаарт музейн түүх бичлэг, монголын музейн сан хөмрөгийн бүртгэл баримтжуулалтын товч түүх, өнөөгийн байдал болон ховор нандин үзмэрүүдийн тайлбар судалгаа, музейн үзэгчдийн урсгал зэрэг музейн менежментийн асуудлыг авч үзжээ.

79.1я5

М 865

ЭШФ Т-23236

**Монголын музейн менежмент: Гарын авлага** / Ред. Д.Сүхбаатар, Д.Бумаа.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 520х.- ISBN: 978-99929-67-81-2.



Музейн олон улсын байгууллагын үйл ажиллагаа, Монголын музейн эрх зүйн орчны асуудлууд, музейн үзмэрийн хадгалалт хамгаалалт, гамшгийн менежмент, музейн маркетинг, брэнд бүтээхүй, үзэгчдэд хүргэх үйлчилгээ, музей ба насан туршийн боловсролын хэрэгцээний агуулгыг хамарсан музейн менежментийг хэрхэн хэрэгжүүлэх арга зүйг зөвлөсөн энэхүү гарын авлага нь музейн ажилтнуудын сургалтын хэрэглэгдэхүүн болохоос гадна их дээд сургуулийн оюутан, музей судлаач, сонирхогч хэн бүхэн ашиглах боломжтой.

79.1(1)я2

М 695

ЭШФ Т-23239

Уандерварф, Сандра. **Музейн сан хөмрөгийн бүртгэл: Гарын авлага** =Museum collections inventory: Guidebook / Орч. Г.Ариунзул; Орч. ред. Д.Мөнхтоогоо.- УБ.: Мянганы хас, 2017.- 136х.- ISBN: 978-99978-2-244-4.



Музейн ажилтан, судлаач нарт зориулан “Монголын үндэсний музейн сан хөмрөгт бүртгэлийн зураасан код систем нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд хэвлэгдсэн энэхүү номонд Монголын үндэсний музейд хэрэгжүүлж буй

үзмэрүүдийг зураасан кодлох арга зүйн зөвлөмж болон соёлын өвийн бүртгэлийн олон улсын туршлагын талаар өгүүлжээ.

79.1я2

У 101

ЭШФ Т-23237

## ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Чулуунбаатар До. **Англи-Монгол хэлц хэллэгийн их толь: Б.1.** = Unabridged dictionary of English-Mongolian phrases: Өвөрмөц хэллэг-Хэвшмэл хэллэг-Хэлц үг-Зүйр үг-Хэлц үйл үг-Этгээд үг.- УБ.: Бэмби сан, 2019.- 1206х.- ISBN: 978-99978-3-878-0.



Энэхүү толь бичигт бичгийн хэлний толь, дав дээр хэрэглэгддэг үгийн толь, дуудлагын толь, этгээд үгийн толь, зохиолын хэлний толь, тухайн нэг зохиолчийн хэлний толь, зүйлчлэн сэдэвчилсэн толь, зүйр үгийн толь, цэцэн үгийн толь, ховор үгийн толь, түгээмэл үгийн толь, ижил үгийн толь, эсрэг үгийн толь, ойролцоо үгийн толь, утгын ялгаврын толь, мэргэжлийн үгийн толь, бэрх үгийн толь, нийлэмж үгийн толь, шинэ үгийн толь, эртний үгийн толь, нутгийн аялгууны толь, нэг үндэст үгийн толь, нэр томъёоны толь, түүхэн үгийн толь, үгийн гарлын толь, үгийн үндсийн толь, харь үгийн толь, үйл үгийн толь, хураасан үгийн толь, хүний нэрийн толь, газар усны нэрийн толь, иш үгийн толь, тонгоруу үгийн толь, журамласан үгийн толь зэргийг эмхэтгэн оруулжээ.

81.2Анг-4

Ч 89

/НХУУТ-7/

ЭШФ Т-23076-23078

## АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ

Батмөнх С. **Монгол ардын дууны тайлбарт дээж бичиг:** Монгол ардын дууны домог, гарваль судлал / Хян. Ш.Сүрэнжав; Зөвл. Х.Зандраабайдий, Б.Тунгалаг.- 2 дахь хэвл.- УБ.: Ордпресс, 2019.- 412х.



Тус номонд монгол ардын урт, богино 120 дууны 800 гаруй бадаг, түрлэгийн домог, үүсэл гарваль, шүлэг найраглалын зохиомж, агуулга, ая эгшгийн зохилдлого, хүмүүний ой тогтоолтод бууж, ажил, амьдрал, зан үйлд үзүүлэх уран сайхны нөлөөлөлийг судлан тодорхойлжээ. Судлаач энэхүү бүтээлээ монгол ардын дууны талаархи өөрийн олон жилийн судалгааны цуглуулга, мөн 220 шахам ардын авъяастан, мэргэжлийн дуучдын яриа, 150 гаруй ном товхимол, сонин сэтгүүлийн нийтлэл, архивын материалаар баяжуулан баталгаажуулсан байна.

82.3(1)+85

Б 337

/НХУУТ-3/

ЭШФ Т-23126-23127

**Захчин аман билгийн жишээ** / Эрхл. Д.Өрнөхдэлгэр; Ред. Т.Баясгалан, С.Гантөмөр.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 304х.- (Аман зохиол, аялгууны алтан сан №1).- ISBN: 978-9919-21-264-2.



Энэхүү ном нь захчин түмний аман зохиолын гарал үүсэл, хөгжил уламжлал, өвөрмөц онцлогийг нээн илрүүлсэн монгол туулийн нэгэн сонирхолтой дурсгал бөгөөд хааны хэмжээгүй эрх цааз, харгис хатуу засаглал, шударга бус хууль зарлигаар албат нараа хохироон шийтгэж байсныг эсэргүүцсэн ардын санааг туулийн хэлээр илэрхийлсэн ажээ.

82.3(1)

3-323

ЭШФ Т-23123-23125

**Мянгад аман билгийн жишээ** / Эрхл. Д.Өрнөхдэлгэр; Ред. Б.Даваадорж, А.Батсуурь.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 200х.- (Аман зохиол, аялгууны алтан сан №2).- ISBN: 978-9919-21-264-3.



Ховд их сургуулийн Хэл зохиолын тэнхимээс жил бүр зохион явуулдаг оюутны хээрийн судалгааны баялаг материалд тулгуурлан хэвлүүлсэн энэ номонд мянгад ястны тоглоом наадам, дом шившлэг, магтаал ерөөл, даллагын шүлэг, аман яруу найраг, үлгэр домог, хууч яриа, ардын дуу, оньсого, зүйр цэцэн үг, зан заншилаас толилуулж байна.

82.3(1)

М 991

ЭШФ Т-23116-23118

**Тууль судлаач Туяабаатар:** Дурсгалын түүвэр / Эрхлэн хэвлүүлсэн Д.Өрнөхдэлгэр; Эмхт. ред. Б.Бямбадорж.- УБ.: Соёмбо принтинг, 2019.-191х.- (Эрдэм шинжилгээний ойллого №06).- ISBN: 978-99978-4-586-3.



МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн монгол хэл-уран зохиолын тэнхимийн ахлах багш, доктор, Ховд их сургууль төгсөгчдөөс төрсөн анхны эрдэмтэн, монгол тууль судлаач Лха.Туяабаатарын намтар, уран бүтээл, түүний тухай анд нөхдийнх нь дурсамжууд багтжээ.

82.3(1)

Т 709

ЭШФ Т-23119-23120

**Өрнөхдэлгэр Д. Элжгэн халхын утга соёл, аман зохиолын уламжлал**=Intangible culture of eljgen khalkha, oral tradition / Ред. С.Дулам, Р.Чүлтэмсүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 356х.- ISBN: 978-9919-21-262-9.



Энэ бүтээлд "Элжгэн" хэмээх нэрийн учир, элжгэдийн нүүдэл суудал, гарал, элжгэн халхын салбар аман аялгууны онцлог, байгаль шинжих мэдлэг ухаан, тоглоом наадгай, сан тахилга, угсаатны бүлгийн хоч шүлэг /ястан хоорондын үнэлэмж/, сүлд, цэнгэх ёс, жонжуу хөөх найр, газар усны нэрийн домог, сүү цагаан идээ боловсруулах, даахь авах ёс, хорио цээрийн ёс, гоёл чимэглэл, саах зөрүүлэх, морины дэл засах, хурдан морь шинжих, мал сэтгэрлэх, ардын дуу хуур, амаг зохиол, цагаан сарын ёсны талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

82.3(1)

Ө 909

/ЭШФ-2, НХУУТ-3/

ЭШФ Т-23121-23122

## УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Батжаргал Д. **Хүүхэд, уран зохиол, бид гурав:** Монголын зохиолчдын эвлэлийн 90 жилийн ойд зориулав / Ред. Д.Лхагвадорж.- УБ.: Бэмби сан, 2019.- 176х.- ISBN: 978-9919-22-628-2.



Д.Батжаргал нь сэтгүүл зүй, хүүхдийн уран зохиолын судалгааны чиглэлээр мэргэшсэн хүн агаад хүүхдийн 28 ном зохиол, 13 сурах бичиг, 32 эрдэм шинжилгээний өгүүлэл бичжээ. Түүний энэ бүтээлд хүүхдийн зохиол бүтээлд хийсэн судалгаа, шүүмж, тэмдэглэлүүд нь оржээ.

83.8(1)

Б 335

/НХУУТ-6, ГНОФ-5/

ЭШФ Б-29575-29577

Дагвадорж Ч. **Сэтгэлийн их мөрний харигийг гайхашран ширтэгчийн өчил: Б. 1** / Ред. С.Байгалсайхан.- УБ.: GZ пресс, 2018.- 372х.- ISBN: 978-99978-4-821-5.



Өнгөрсөн зууны утга зохиолын амьдралын ээдрээт замналын зарим нэгэн хэсгийг улам бүр тодотгон өгөх баримт материал, судлан шинжилсэн дүгнэлтүүдийг багтаасан энэхүү бүтээл нь XX зууны утга зохиолын түүхийг дахин харж, шинээр судлан сурвалжилж буй эрдэмтэн судлаачдад санаа өгөх цаг үеэ олсон чухал бүтээл болсон ажээ. Тус бүтээлд XIX-XX зууны зааг дахь Монголын уран зохиолын үндсэн хандлага, өвөрмөц зарим асуудал, XX зууны монголын уран зохиолын үечлэл, онцлог шинж, Монголын орчин үеийн яруу найраг, өгүүллэг, тууж, роман, жүжиг, кино зохиолын хөгжил, утга зохиолын судлал, шүүмжлэлийн асуудлыг хөндсөн тухайн цаг үеийн төлөөлөгчдийн бүтээлүүд орсон байна.

83.3(1)

Д 156

/НХУУТ-2/

ЭШФ Т-23105-23106

Дагвадорж Ч. **Хөхөөн дууны эгшиг буюу яруу тайлал: Б. 2** / Ред. А.Мөнх-Оргил.- УБ.: GZ пресс, 2018.- 372.- ISBN: 978-99978-4-822-2



Уг бүтээлд утга зохиолын шүүмж судлалын тодорхой цаг үеийн төлөөлөл болохуйц 20 гаруй судлаачийн бүтээлийг тусгайлан авч, тэдний шүүмж судалгаанд дахь судлаачийн үзэл баримтлал, хандлагыг шинжлэн тодорхойлж, судлаач хүн уран зохиолын орчинд гарч буй үзэгдлийг алдалгүй харж, түүнийг өөрийн үзэл сэтгэлээр таньж чадсанаар зөв чиг баримжаа тогтоох буюу уран сайхны үзэгдэлд зарчмын байр суурь баримтлах, үнэлгээ өгөх, дүгнэн тодорхойлох боломжтойг их эрдэмтний зүгээс зөвлөн сануулсан байна.

83.3(1)

Д 156

/НХУУТ-2/

ЭШФ Т-23107-23108

Дагвадорж Ч. **Хоолой торолзуулсан Хотогойд дуу: Б. 3** / Ред. Ш.Баттөр.- УБ., 2018.- 332х.- ISBN: 978-99978-4-823-9.



Энэхүү бүтээлд Хотогойд дуунд шингэсэн эх нутаг, их түүх, угсаа гарвалаараа бахархсан бүтээл төрөхүйн нууц болоод ард олны дунд түгсэн олон дуунуудын түүх, мөн дууны түүхэнд холбогдох хүмүүсийн тухай сонирхолтой тэмдэглэлүүд багтжээ.

83.3(1)

Д 156

/НХУУТ-2/

ЭШФ Т-23109-23110

Дагвадорж Ч. **Монголын утга зохиолын тайлбартай лавлах товчоон: Б. 4** / Ред. Х.Сүглэгмаа.- УБ., 2018.- 352х.- ISBN: 978-99978-4-824-6.



Тус бүтээлд XIII-XIV зууны эхэн үеэс XX зууны төгсгөл үе хүртэлх Монголын бичгийн уран зохиолын түүхэнд холбогдох мэдээллийг хураангуйлан нэр томъёог үсэг дарааллын зарчмаар жагсаан товч тодорхой тайлбарласан лавлах толийг бүтээсэн байна.

83.3(1)

Д 156

/НХУУТ-2/

ЭШФ Т-23111-23112

Нандинбилиг Г. **Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй** / Ред. С.Дулам.- УБ.: МУИС пресс, 2018. – 312х.- ISBN: 978-99978-4-845-1.



Тус номонд уран зохиолын гурван төрлөөр задлан шинжлэх арга зүйг чиглүүлсэн үндсэн гурван бүлгээс гадна их сургуулийн ерөнхий суурийн "Уран зохиолын боловсрол" хичээл болон ерөнхий боловсролын сургуулийн сонгон суралцах хичээлийн агуулга, арга зүй хийгээд тус хичээлээр суралцагчийн цогц чадамжийг үнэлэх арга зүйн талаар тусгажээ.

83.3

Н 28

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ-Т-23113-23115

Хишигсүх Б. **Монголын сонгодог утга зохиолын судлал** / Хян. Ц.Лхагвасүрэн.- УБ.: Жиком пресс, 2019.- 268х.- (Утга зохиолын судлал шинжлэл: Цувр.35).- ISBN: 978-99978-60-83-5.



МУИС-ийн багш, доктор, профессор Б.Хишигсүх монголын эртний уран зохиол, тэр дундаа Инжаннаши судлалаар голлон судалгаа хийдэг бөгөөд "Хөх судар"-ын хоёр эхийн утга, уран сайхны харьцуулсан судалгаа сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсан. "Утга зохиолын судлал шинжлэл" цувралын энэ удаагийн 35 дахь ботид түүний Инжаннаши, Равжаа судлал болон "Монголын нууц товчоон"-ы судлалаар бичсэн өгүүллүүдийг эмхэтгэн оруулжээ.

83.3(1)

Х 377

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б-29558-29560



**Чингисийн монголын тэнгэрлэг зохиолчид:** Цаасан хөрөг хайчилбар, сонгомол бүтээл туурвил, дурсамж, дуртгал.- УБ.: Жиком пресс, 2019.- 352х.- (Бадрангуй урлаг ТББ).- ISBN: 978-99978-4-800-0.



Энэхүү бүтээл нь судлаач Ц.Галбадрахын хайчилбар хөрөгт суурилан бүтээгдэж буй гурав дахь хэвлэл бөгөөд эрхлэн гаргагч байгууллагаас яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол, жүжгийн зохиол, хүүхдийн зохиол, шог хошин зохиол, орчуулга, утга зохиол судлал гэсэн 7 төрлөөс төлөөлөн багтаахыг зорьжээ. Д.Нацагдорж, эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Ж.Бадраа нараас эхлүүлэн орчин цагийн шилдэг залуу зохиолчдийг хамарсан нийт 90 уран бүтээлчийг сонгож, монгол түмний сэтгэлд хоногшсон Миний нутаг, Монгол нутаг, Монгол хэл, Халуун элгэн нутаг зэрэг 90 шилдэг бүтээлийг багтаасан байна.

83.3(1)

Ч 63

/НХУУТ-4/

ЭШФ Т-23135-23137

## УРАН ЗОХИОЛ

**Батбаяр Мө. Өртөөн дээр хэлэгддэг үгс.-** УБ., 2019.- 82х.

Зохиолч энэхүү номондоо энэ өртөөн дээр хэлэгддэг үгс шиг, өртөөн дээрээс миний олж сонсдог үгс шиг тийм л сайхан зүйлсийг би яруу найрагтаа цогцлоож, тэр сайхан цэцэрлэг дундуур маань түмэн олон жарган орчдог байх ёстой гэж бодсон болохоор галт тэрэг, өртөөгөөр өнгөрөөсөн сүүлийн хэдэн жилийн шүлгүүдээ багтаажээ.



84(1)-5

Б 332.

/НХУУТ-3/

ЭШФ Б-29565-29566

**Вэньшюань Цао. Гал тамга / Орч. Ш.Эгшиг; Хян. Ван Хао.-** УБ.: Удам соёл, 2018.- 448х.- ISBN: 978- 99978-4-921-2.

Цао Вэньшюань бол Хятадын алдартай хүүхдийн зохиолч бөгөөд түүний олон зохиол англи, франц, герман, япон, солонгос зэрэг 16 хэлнээ орчуулагджээ. Түүний "Гал тамга" зохиол нь Японыг эсэргүүцэх дайны үеийн үйл явдалд суурилан Цасан хэмээх нэгэн ухаантай морь, түүний бяцхан эзэн Пагваа нарын хагацаж, хэрхэн эргэн уулзаж буй талаар дүрсэлжээ.

84(5Хят)-4

В 97

ЭШФ Б-29623-29624



**Гүн-Үйлс Д. Солонгон хөндий. –** УБ.: Соёмбо принтинг, 2019.- 390х.- ISBN: 978-99978-55-19-0.

Солонгон хөндий роман нь “Зүүд шиг амьдрал”, “Амьдрал шиг зүүд”, “Зүүд ба амьдрал” гэсэн гурван бүлэгтэй. Ер нь хүний амьдралын ихэнх хэсэг хийсвэр орон зайд өнгөрдөг. Гуниг, гэмшил, дурсамж, санаж сэрэхүй, бодож бясалгахуй, хүсэл мөрөөдөл, хүлээлт гээд. Энэ бүхэн бол хүний сэтгэлийн мөн чанар юм. Хүн хорвоогоос буцахдаа ч сэтгэлийн тэр л орон зай руугаа буцах билээ...Хүн



төрөлхтний мөнхийн сэдэв бол хайр. Хайр ямар ч нөхцөлд мөнхөд ялдаг гэдгийг энэ романд өгүүлсэн бөгөөд “Солонгон хөндий” бол гэгээн тунгалаг хайрыг мөнхөлсөн зохиол ажээ. Уншигч та ч энэ романыг уншиж Манжийн үеэс их хэлмэгдүүлэлтийн үеийг дамжин өнөөг хүрсэн түүхийн их жимээр аялж, уран тансаг монгол хэлний сайхныг мэдэрч болох юм.

84(1)-44

Г 852

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-29544-29546

Дашдондов Д. **Зохист гүн Арван дөрөвтийн эрих** / Ред. Н.Мөнхбаяр; Зур. Д.Дашдондов.- УБ.: Жиком пресс, 2019.- 108х.- ISBN: 978-9919-22-516-2.



Д.Дашдондовын энэхүү бүтээл нь сонетийн эрих буюу арван дөрөвтийн эрихүүдээр дагнан бүтжээ. Сонетийн эрих нь утгын хувьд юмс үзэгдлийн дотоод мөн чанарт гүн нэвтэрч бодрол ухаарал, сэтгэмж, сэтгэлгээ шүтэн барилдсан, хэлбэрийн хувьд чанд бэрх уран шийдэлт цогц шинжтэй байдгаараа яруу найргийн хамгийн адармаатай хэлбэр юм.


84(1)-5

Д 393

/НХУУТ-3/

ЭШФ Б-29567-29568

Дашдондов Д. **Сэтгэлийн урлан** / Ред. Н.Батжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 132х.- ISBN: 978-99978-4-461-3.



Физикч, зохиолч, яруу найрагч Дамбийн Дашдондов яруу найргийн "Сэтгэлийн урлан" хэмээх шинэхэн түүврээ уншигчиддаа хүргэж байна. Энэхүү бүтээлд зохиолчийн сэтгэлийн гүндээ урлан хэлхсэн хайр, харуусал, утга уянгын ухаарал бодрол хайрласан шүлгүүд багтсан байна. Тэрээр өмнө нь яруу найргийн 10-аад ном, драмын жүжгүүд, хөгжимт драм, фольк дуурь, кино зохиол зэрэг олон бүтээлүүд туурвисан билээ.

84(1)-5

Д 393

/НХУУТ-3/

ЭШФ Б-29561-29562

**Дэлхийн сонгодог утга зохиол** / Орч. О.Чинбаяр.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- ISBN: 978-9919-9512-3-8.

84(0)-44

Д 893

**Б.1. Мэлвилл Хэрман. Моби Дик буюу цагаан халим.- 480х.**

Энэхүү романы ихэнх үйл явдал тэр чигээрээ далай тэнгист өрнөж буйгаараа онцлог билээ. Тэр тусмаа хоёр их гүрний дунд оршдог эх газрын манайх шиг орны уншигчдын хувьд далайн амьдрал сонирхол татаж мэдэх юм. Халим судлалын нэвтэрхий толь гэгддэг энэхүү романд хүн, байгалийн харьцаа, тэдгээрийн харилцан шүтэлцэл хийгээд эсрэг тэсрэг байр суурийг тод томруун харуулжээ.




ЭШФ Б-29578-29579

## Б.2. Жойс Жэймс. Дүблинчүүд.- 272х.

Энэхүү Дүблинчүүд түүвэрт орсон өгүүллэгүүд нь 1904-1907 оны хооронд бичигдсэний дээр реалист ЭШФ Б-29580-29581 чиглэлийн бүтээлүүд бөгөөд тухайн цаг үеийн нийгмийн харанхуй, бүдүүлэг дорой байдлыг шүүмжилсэн төдийгүй Европын утга зохиол, тэр тусмаа өгүүллэгийн хөгжилд шинэ уур амьсгал, шинэ үе шатыг авчирч чаджээ.

ЭШФ Б-29580-29581



## Б.3. Жойс Жэймс. Зураачийн залуугийн хөрөг.- 340х.

Энэхүү "Зураачийн залуугийн хөрөг" роман нь нэг талаараа Ирландын зохиолч Ж.Жойсийн хувийн амьдралаас сэдэвлэсэн гэж хэлж болно. Энэхүү зохиолд "Үлисс" романы дүр болох Стивен Дедалын хүүхэд ахуй насыг тодорхой харуулдаг бөгөөд зохиолын баатрын нэр нь хиймэл далавч бүтээсэн эртний Герегийн инжаан Дедалын тухай домгоос үүдэлтэй ажээ. Үүнээс гадна тухайн роман дахь Стивен Дедалыг Ж.Жойсийн өөрийнх нь дүр гэж үздэг билээ.

ЭШФ Б-29582-29583




## Б.4. Жойс Жэймс. Үлисс-1.- 396х.- (1-12-р хэсэг)

Үлисс хэмээх аугаа роман долоон жилийн турш бичигдсэн агаад урлагийн бурханлаг бүтээл төдийгүй анх удаа Америкийн "The Little Review" сэтгүүлд 1918-1920 онд хэсэгчлэн нийтлэгджээ. Улмаар 1922 онд Францад бүрэн эхээрээ хэвлэгдсэн бол өдгөө бараг 100 жилийн өмнө туурвисан эл адармаатай зохиол дэлхийн ердөө 14 хэл дээр орчуулагдаад байна. (1-12-р) хэсгийг хамруулжээ.

ЭШФ Б-29584-29585

## Б.5. Жойс Жэймс. Үлисс-2.- 374х.- (13-18-р хэсэг)

ЭШФ Б-29586-29587



## Б.6. Уайльд Оскар. Дориан Грэй хөрөг.- 208х.

Оскар Уайлдын энэхүү роман нь түүний хувьд хэвлэгдсэн цорын ганц зохиол билээ. Төрөл зүйлийн тухайд, сурган хүмүүжүүлэх өнгө аяс бүхий роман, сургамжит үлгэрийн холимог байдлаар бичигджээ. Энэхүү зохиолын хоёр ч хувилбар бий. Эхнийх нь нийт 14 бүлэгтэй, 1890 онд бичигдсэн бол удаах нь 20 бүлэгтэй, 1891 онд олны хүртээл болжээ. О.Уайлдын энэхүү бүтээл түүнийг алдрын титэм хүртэхэд нөлөөлсөн шилдэг зохиол нь агаад өдгөө дэлхийн 30 гаруй оронд дэлгэцийн бүтээл болсон байна.

ЭШФ Б-29588-29589



## Б.7. Кафка Франц. Шүүх ажиллагаа.- 224х.

"Шүүх ажиллагаа" хэмээх энэхүү роман амиа егүүтгэх нь Бурханыг жинхэнээсээ баясгадаг хүмүүний амьдралын цорын ганц төгсгөл гэдгийн нотолгоо болохыг харуулдаг. Тиймээс илүү зүйл нуршилгүй тухайн цаг үеийн шүүх засаглалын хүнд суртал, хээл хахуульд автсан байдал, шүүх ажиллагаа хэзээ ч гэм зэмгүй сэжигтний талд үл шийдэгдэж байсан тэрхүү хуулийн завхрал, гажуудлын тогтолцоог уран зохиолын аргаар дүрслэн харуулжээ.

ЭШФ Б-29590-29591



**Б.8. Платонов Андрей. Чевенгүр.- 424х.**

Уг роман нь нэг ёсондоо егөөдсөн хошин өнгө аястай бүтээл бөгөөд мөн түүний дотор аугаа их эмгэнэл, хий мөрөөдөл, шашны сүжиг зэргийг ч багтаасан ажээ. Зөвлөлт засгийн хувьсгалын дараах үл гүйцэлдэх үзэл санаа бүхий бүтээн байгуулалтыг ил далд хэлбэрээр шүүмжилсний төлөө А.Платоновын энэхүү бүтээл бичигдсэн цагаасаа хойш нэгэн жарны дараа хэвлэгдэн гарч олны хүртээл болж байна.

ЭШФ Б-29592-29593



**Б.9. Хэссэ Хэрман. Талын чоно.- 268х.**

Тус романы үйл явдал Галлерын амьдралын бараг гурван долоо хоногийг хамарна. Хэсэг хугацаанд Талын чоно нэгэн жижигхэн хотод амьдарч байгаад дараа нь тэндээс ор мөргүй арилахдаа өөрийнхөө "Тэмдэглэл"-ийг үлдээсэн нь тус романы ихэнх хэсгийн эзэлнэ. Тэрхүү "Тэмдэглэл"-д хорвоо дээр өөрийнхөө орон зайг олж чадахгүй байгаа, гагцхүү амиа егүүтгэх бодлоор амьдарч, амьдрал гэдэг түүний хувьд өдөр бүр зовлон мэт санагдах тийм л нэгэн билиг танхай авъяаслаг хүний дүрийг харуулжээ.

ЭШФ Б-29594-29595



**Б.10. Соколов Саша. Тэнэгүүдийн сургууль чонохой.- 398х.**

Энэхүү роман "ухамсарын урсгал" бүхий модернист хэв маягаар туурвигдсан агаад зохиолын гол баатрын дотор хүнтэйгээ ярьж буй ганц хүний яриа мэт хүүрнэн өгүүлэх хэлбэрээр бичигджээ. Гол баатар нь тэнэгүүдийн сургуульд суралцдаг нэгэн боловч анагаахын шинжлэх ухааны үүднээс авч үзвэл, тэнэг гэдэг нь түүнд тавьсан онош биш харин тухайн баатрын ертөнцийг мэдэрч буй тэрхүү онцгой, хоёрдмол мэдрэхүй бөгөөд бодит байдал, өнгөрснийг хамтад нь нэг дор хольж хутган мэдэрч буй явдал билээ.

ЭШФ Б-29596-29597



Жиан Чи Зи. Цасан хөшиг / Орч. Мө.Батбаяр; Ред. Б.Молор-эрдэнэ, Г.Хэрлэнцэцэг.- УБ.: Сэлэнгэпресс, 2019.- 260х.- ISBN: 978-9919-21-311-4.

Энэхүү номын зохиолч Чи Зи Жиан нь эдүгээ дундад улсын уран зохиол сонирхогч хүн бүр бүтээлийг нь унших дуртай зохиолч төдийгүй нэг, хоёр, дөрөвдүгээр удаагийн Лү Синий нэрэмжит утга зохиолын шагнал, долоодугаар удаагийн Мао Дуны нэрэмжит шагнал, шилдэг эссэ найруулалд олгодог Бин Синий нэрэмжит шагнал хүртэж, зохиол бүтээлүүд нь Англи, Франц, Япон зэрэг дэлхийн олон хэлнээ орчуулагдсан байна. Тэрээр эмэгтэй хүний оршихуй, ертөнц, эмэгтэйчүүд ба хүн, байгаль, нийгмийн харьцаа, тэдний бодрол ухаарал, гуниг ганцаардлын сэдвээр голчлон бичдэг. Энэ өгүүллэгт гарч буй ухаарч цөхсөн, хүлээж ганцаардсан эмэгтэйчүүдийн дүр бол товчхондоо зохиолч Чи Зи Жиан өөрөө л юм өөр хэн ч биш... гэж судлаачид үздэг.

84(5Хят)-44

Ж 63

/НХУУТ-3/

ЭШФ Б-29563-29564



**Монголын нууц товчоо.**- УБ.: Соёмбо пресс, [2019].- 234х.- ISBN: 978-999622384.



Монголын түүхийн хосгүй үнэт дурсгал болох энэхүү зохиолыг манай нэрт эрдэмтэн судлаачид кирилл үсэгт хөрвүүлэн буулгаж, орчин цагийн уншигчдад түгээн дэлгэрүүлж байгаа билээ. Энэ удаагийн танилцуулж буй хэвлэл нь их эрдэмтэн Цэндийн Дамдинсүрэн гуайн хөрвүүлсэн эхээс хуулбарлан буулгасан байна.

84(1)

М 695

/НХУУТ-17, ГНОФ-80/

ЭШФ Б-29598-29600

**Ойрхон: Өвөр Монгол залуу шүлэгчдийн түүвэр** / Эмхт. Д.Нямдорж; Хөрв. Ө.Балжинням.- 2 дахь хэвл.- УБ., 2019.- 70х.- ISBN: 978-9919-21-787-7.



Энэхүү шүлгийн түүвэрт Өвөр Монголын шинэ үеийн яруу найргийн талаар тодорхой ойлголт өгөхүйц оюун санааны сэрэл мэдрэмжийн шүлгүүдийг голчлон сонгож оруулжээ.

84(545)-5

О-246

/НХУУТ-7/

ЭШФ Б-29555-29557

**Тэнгэр хүлэгтэн:** Хаан цадиг, хатан цадиг, жанжин цадиг: Түүхэн сэдэвт туужийн уралдаанд шагналт байр эзэлсэн бүтээлүүд / Ерөн. ред. Д.Гүн-Үйлс.- УБ., 2019.- 495х.- ISBN: 978-99962-73-17-9.



Эл эмхэтгэлд Хаан цадиг, Хатан цадиг, Жанжин цадиг хэмээх гурамсан бүтээлээс тэргүүлсэн туужуудыг нэгэн дор эмхэтгэн тусгажээ. Уг бүтээл нь мөнх тэнгэрээ дээдэлж, монгол соёлын зүрхэн сүлд болсон хүлэг морио эрхэмлэж ирсэн түүхэн улбааг хүндэтгэсэн үндэсний утга зохиолын охь дээжсийн тоонд зүй ёсоор орох бүтээлийн нэг ажээ.

84(1)-44

Т 901

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-2952629528

**Цоодол Д. Ганзагалаа:** Эсээ, хөрөг, тэмдэглэл, ярилцлага, нөхдийн айлдвар / Нягт. Д.Цэнджав.- УБ.: Сэлэнгэпресс, 2019.- 416х.- ISBN: 978-9919-21-222-3.



Их найрагч, дууль найргийн том төлөөлөгч Дөнгөтийн хөвүүн Цоодолын “Ганзагалаа” бүтээл нь эсээ, хөрөг, тэмдэглэл, ярилцлага, нөхдийн айлдвар гэсэн таван бүлгээс бүрдэх ба энэхүү эр суран ганзагалаанд нь монгол эр хүний саруул ухаан, уужуу сайхан сэтгэлийн өнгө юутай дүүрнээр жигдэрч эмхэглэгдснийг ажигч байтугай анзаараггүй нэг нь ч мэдрэхээр үлдээн бичжээ. Түүний бүтээлээс өөр хоорондоо холбоотой бүхэл бүтэн амьдралын цогцлол, нүд чихний зөрүү ялгасан ухаан, туулсан замнал, учрал зохиол, өнгө өнгөөрөө араншин араншингаараа ялгаран буйг эрхэм уншигч та ухаарах буй заа.

84(1)-44

Ц 782

/НХУУТ-4/

ЭШФ Б-29529-29531



Джованьоли Рафаэлло. **Спартак: 1-р боть** / Орч. М.Халиун.- УБ.: Адмон, 2017.- 464х.- ISBN: 978-99978-1-481-4.



Спартак романы зохиолч Рафаэлло Джованьоли /1838-1915/ Италийн Гарибальдийн армид алба хааж, өөрийн эх орныг чөлөөлөх дайнд оролцож явжээ. Зохиолч эртний Ромын МЭӨ 74-73 онд боссон боолуудын агуу том бослогын түүхэнд үндэслэн энэхүү Спартак зохиолоо бичихдээ тэрхүү түүхэнд алдартай бослогын удирдагч болох боол, гладиатор Спартакийн асар их ухаан хүч чадалтай, цэргийн агуу авъяаслаг жанжин байсныг тодотгон харуулахыг зорьжээ. Уг эх зохиол нь бүгд 22 бүлгээс бүрдэх бөгөөд энэхүү монгол орчуулгыг 2 боть номд хуваан толилуулж байна.

84(4Ита)-44

Д 40

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-29532-29534

Мопассан Ги Де. **Сувд эрдэнийн хатагтай**: Тууриуд / Орч. Д.Цоодол; Техик ред. Б.Төгсжаргал, Б.Бадамханд.- 3 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 456х.- ISBN: 978-99962-58-95-4.



XIX зууны Францын нэрт зохиолч, хожуу үеийн олон суутнуудад уран бүтээлийнх нь багш гэж дээдлэн хүндлэгдэх болсон Ги Дэ Мопассан нь /1850-1893/ "Үнхэлцэг" "Фифи хатагтай" "Соваж эмгэн" "Симоны аав" "Өв хөрөнгө" өгүүллэг "Амьдрал" "Хонгор найз" зэрэг романаараа алдаршсан байдаг. Тэрээр өгүүллэгүүддээ юуны өмнө Франц-Пруссийн дайны тухай гол төлөв дүрсэлсэн бөгөөд ялангуяа "Фифи хатагтай" "Соваж эмгэн" зэрэг өгүүллэгтээ жирийн хүмүүсийн эх оронч сэтгэлийг өвөрмөц үзүүлсэн байна. Түүний энэхүү "Сувд эрдэнийн хатагтай" бүтээлд дээр дурдсан зарим алдартай өгүүлэл болон бусад хэд хэдэн сонирхолтой өгүүлэл тууриуд нь орсон байна.

84(4Фр)-44

М 71

/НХУУТ-4/

ЭШФ Б-29535-29537

**Хүүхдийн уран зохиолын унших бичиг**: ЕБС-ийн сурагч, их дээд сургуулийн оюутнуудад зориулав / Эмхт. А.Амардалай, Б.Нанжид, О.Сундуй; Хян. Г.Бямбацэрэн, Д.Хүү, Н.Даваасүрэн.- УБ.: Тоонотпринт, 2019.- 328х.- ISBN: 978-99978-1-813-3.



Энэхүү бүтээл нь Монголын эртний уран зохиол, Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол, шүлэг, өгүүллэг, тууж гэсэн агуулгатай. Мөн шинэ үеийн уран зохиолын эхэн үеэс өнөөдрийг хүртэлх хүүхдэд зориулсан зохиолуудаас агуулгын ач холбогдол, уран дүр, дүрслэлээрээ хамгийн шилдгийг нь сонгон оруулжээ.

84(1)-4


Х 856

/НХУУТ-2/

ЭШФ Т-23163-23164

## УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ

**Дуунд мөнхөрсөн баатрууд:** Халхын голын дайны ялалтын 80 жилийн ой, чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойд зориулав / Эмхт. Г.Ганбат; Ред. Б.Отгонбаяр.- УБ., 2019.- 105х.



Уг номонд 1921 оны Ардын хувьсгал, 1939 оны Халхын голын болон 1945 оны Чөлөөлөх дайн, 1944-1948 оны Баруун хилийн тулгаралт, байлдаанд оролцож БНМАУ-ын баатар цол хүртсэн 46 гавьяатуудад зориулан зохиосон дуунуудыг шүлэг, нотны хамтаар эмхэтгэсэн бөгөөд тэдгээрийн дотор яруу найрагч, чөлөөнд байгаа хурандаа Г.Ганбат өөрөө 21 дууг хөгжмийн зохиолчидтой хамтран бүтээсэн ажээ.

85.319

Д 72

/НХУУТ-3/

ЭШФ Т-23130-23132

## ШАШИН СУДЛАЛ

**Лхагвасүрэн Г. Ноён хутагт Данзанравжаа:** Гүн ухааны үзэл: Орчин үеийн монголын сэтгэл төдийтний гүн ухаантан, доктор, профессор Гүржавын Лхагвасүрэн агсны мэдэлсний 60 жилийн ойд зориулав.- 3 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 251х.- (Эрдмийн бүтээл Б.1).- ISBN: 978-99978-4-491-0.



Тус бүтээлд дэлхийн шилдэг философич өргөмжлөлт доктор, профессор Гүржавын Лхагвасүрэн буддизмыг монгол орноо бүтээлчээр дэлгэрүүлж байсан цаг үе, нөхцөл байдал, энэ үйл хэрэгт ноён хутагт Данзанравжаагийн оруулсан хувь нэмэр, хоосон чанар, бодь сэтгэл, шүтэн барилдлага, бурханы шашны шинэчлэл зэргийн талаарх түүний үзэл санаа, гүн ухааны сэтгэлгээ зэргийн тухай дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Г.Лхагвасүрэнгийн эл бүтээл нь Лондон дахь Төвдийн фондтой хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд МУИС-ийн Буддын соёл судлалын төвөөс эрхлэн хэвлүүлж буй 7 дахь ном ажээ.


86.35(1)+87.3

Л 874

/НХУУТ-3/

ЭШФ Б-29615-29616

**Лхагвасүрэн Г. Сэтгэл төдийтний гүн ухаан:** Орчин үеийн монголын сэтгэл төдийтний гүн ухаантан, доктор, профессор Гүржавын Лхагвасүрэн агсны мэдэлсний 60 жилийн ойд зориулав / Эх бэлт. Л.Ариунболд, Л.Ариунболор, Б.Үүрийнтуяа; Хавтасны дизайнер Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 215х.- (Эрдмийн бүтээл Б.2).- ISBN: 978-99978-4-492-7.



Эл номыг зохиогч нь Монголын гүн ухаан, буддын судлалын шинэ үеийн тэргүүлэх томоохон төлөөлөгчдийн нэг, Дэлхийн шилдэг философич өргөмжлөлт доктор, профессор Гүржавын Лхагвасүрэн агсан юм. "Эрдмийн бүтээл" цувралын 2-р ботид Буддын гүн ухааны сэтгэхүй дэх сэтгэл төдийтний чиглэлийн гүн ухааны агуулга, ач холбогдлыг тодруулан авч үзжээ. Уншигч авхай нарт өргөн толилуулж буй тус бүтээл нь буддын философийн суурь бүтээл, багш судлаачдын судалгаа сургалтын ажлын үндсэн хэрэглэгдэхүүн болох аж.

86.35

Л 874

/НХУУТ-3/

ЭШФ Б-29613-29614

**Монгол дахь буддын судлал ба нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудалд:** Доктор (Ph.D), профессор Г.Лхагвасүрэнгийн мэндэлсний 60 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, дурсамжийн эмхэтгэл / Ред. С.Цэдэндамба; Эмхт. Б.Мөнхцацралт; Эх бэлт. Н.Оюунбилэг ; Хавтасны дизайнер Н.Оюунбилэг.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 272х.- ISBN: 978-9919-9556-2-5.



Доктор, профессор Гүржавын Лхагвасүрэн агсны мэндэлсний 60 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын энэхүү эмхэтгэл нь "Монголын буддын судлал, монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн судлал, Ноён хутагт Данзанравжаа судлал, сэтгэлийн тухай буддын сургаал судлалд холбогдох илтгэлүүд", "эгэл даруу атлаа дэлхийд танигдсан эрдэмтэн, эрдмийн олон шавьтай эрхэм хүндэт багш, өрх гэрийн өмөг түшиг, үр хүүхдийнхээ элбэрэлт эцэг байхын үлгэр дууриаллыг үзүүлэхийн зэрэгцээ намын биш номын ухаанаар улсаа удирдах, төрөө засахыг Монгол улсынхаа төрийн тэргүүнд зөвлөж явсан энэ хүний тухай эрхэмсэг хийгээд энгүүн дурсамж", "эрдэмтний бүтээлийн жагсаалт, зургийн цомог" гэсэн 3 хэсэгтэй.

86.35(1)

М 692

/НХУУТ-3/

ЭШФ Т-23201-23202

**Монгол улсын сүүлчийн эзэн хаан, наран гэрэлт, түмэн наст, оройн дээд Очирдарь наймдугаар богд Жэвзүндамба хутагтын буман зарлиг Монгол улсын хаан, VIII Богд Жавзандамба хутагтын мэлмий гийсний 150 жилийн ойд зориулав** / Орч. Б.Идэрбаяр.- УБ.: Бишрэлт тэнгэрийн дардас, 2019.- 329х.- 978-9919-21-007-6.



Энэхүү зохиол нь /1872-1922 он/ хэвлэсэн он тодорхойгүй ч ерөнхийдөө түүний зарлигийн зохиол болох "Төгс жаргалант эх"ийг 12 сүүдэртэйдээ айлдсанаас авахуулаад айлдсан нийт айлдваруудын засваргүй эхүүд, өөрийнх нь намтар зэрэг тухайн үед улс орон даяар өрнүүлэн, өөрөө санаачлан, удирдаж байсан үйл хэрэг, нэгэн цаг үед амьдарч байсан түүхэн хүмүүсийн нэр алдар дурьдагдсан зохиол зэргээр баримжаалсан болно. Уг эмхэтгэл нь Богд гэгээний бидэнд үлдсэн хайрласан соёлын баримтат өвүүд дотроос, түүний өөрийнх нь зарлиг, бүтээл болохын хувьд, мөн шашин, төр, улмаар төрийг засах хос ёсны баримтлалын түүхэн тодорхой цаг үеийг илтгэхийн хувьд ч түүхийн баримт, хойч үеийнхэнд оюуныг засах сургааль, хуврагийн аймагт санваар сахилыг сахих цааз, төрийн хүмүүнд иргэдээ нигүүлсэн, цааз ёсыг чанд баримтлах суртал, Монгол орны хүн зоны магадын сайн, тусгаар улсын төрийн багана гулзайшгүй бат, шашны олон мэргэдийн өлмий бат, басхүү хойдын төрөл нь эндүүрэггүй төрөхийг ерөөсөн ерөөл зэргийн цоморлиг болохын тухайд ихээхэн үнэ цэнэтэй юм.

86.3(1)

М 692

/ НХУУТ-2/

ЭШФ Т-23073-23075

## ГҮН УХААН



**Мэнзийн сургаал:** Эртний Хятадын гүн ухааны сэтгэлгээний сонгодог судар / Орч. М.Чимэдцэеэ; Хян. Яо Кэчэн.- УБ.: Адмон, 2019.- 270х.- ISBN: 978-9919-21-652-8.

"Тэнхлэгийн эрин үе"-д тодорсон бас нэгэн гүн ухаантан бол Мэнз /НОТӨ 475-221он/ юм. Мэнзийн сургаалын гол цөм нь "Өршөөлт засаглал"-ын тухай номлол хэмээдэг бөгөөд энэ номлолын эх үндэс нь "хүмүүнийг эш болгох сэтгэлгээ" ажээ. Эртний Хятадын гүн ухааны сэтгэлгээний сонгодог судар болох "Мэнзийн сургаал"-ыг орчуулагч М.Чимэдцэеэ монголд анх удаа бүрэн эхээр нь орчуулан уншигч олонд толилуулж байна.

87.3(5Хят)

М 96

ЭШФ Т-23191

**Тогтвортой хөгжил:** Ногоон ёс зүй: Эрдэм шинжилгээний бага хурал / Хян. Р.Дарьхүү, М.Золзаяа, Д.Оюунгэрэл; Эх бэлт. Б.Баттулга.- УБ.: Тотопресс, 2019х.- 278х.- ISBN: 978-9919-504-09-0.



Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэлийг МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимээс эрхлэн хэвлүүлжээ. Тус эмхэтгэлд экологийн ёс зүйн боловсрол, байгаль орчныг хамгаалах уламжлал, экологийн ёс зүйн орчин үеийн онол-практикийн асуудлууд зэрэг чиглэлээр их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын 45 эрдэмтэн судлаачийн 30 илтгэл багтсан байна.

87.7(1)+20.1

Т 441

/НХУУТ-7/

ЭШФ Б-29632-29634

**Төрийн албан хаагчийн ёс зүй:** Гарын авлага / Боловс. Г.Мягмар, М.Нармандах, Ч.Ундрам; Хян. Д.Дуламсүрэн.- УБ.: Урангар пресс, 2019.- 144х.



Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлагдан хэрэгжиж эхэлж буй энэ мөчид төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн онолын үндсэн ойлголт, үнэт зүйлс, баримтлах зарчмууд, ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам, төрийн албан хаагчийн манлайлал ба ёс зүйн ухагдахуун болон төрийн албаны ёс зүйг дээшлүүлэх сайн туршлага ба боломжуудын талаар тус гарын авлагад өгүүлсэн байна.

87.75

Т 594

/НХУУТ-2/

ЭШФ Т-22886-22887

**Эйтаро Коно. 100 хүний 1 нь л хэрэгжүүлдэг ажлын ноу-хау:** Өөрийгөө асаа: Япончуудын ажлын ноу- хау / Орч. Д.Чимээ.- УБ.: Нэпко, 2019.- 181х.- ISBN: 978-99978-51-85-7.



Эйтаро Коно бизнесийн сэдэвтэй хэд хэдэн бэстсэллэр ном бичсэний нэг нь энэхүү бүтээл юм. Энэ ном нь ажилд шууд хэрэг болох ноу-хаугаар дүүрэн төдийгүй шинэ ажилтны ширээний ном болох ажээ.

87.7

Э 318

/НХУУТ-5, БС-5/

ЭШФ Б-29550-29552

### СЭТГЭЛ СУДЛАЛ

Сарантуяа Г. **Зүйр цэцэн үгийн сэтгэл зүйн тайлбар: 2-р дэв.-** УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 238.- ISBN: 978-991922-052-5.



Энэхүү ном нь монгол ардын зүйр цэцэн үгээр илэрхийлэх утга агуулга нь хүний сэтгэл зүйд хэрхэн буух тусгалыг тайлбарлажээ. Монгол ардын хязгааргүй олон зүйр цэцэн үгийг зөвхөн нэг номонд багтаах боломжгүй учир цаашид цувралаар хэвлэгдэх бөгөөд энэ удаад 2-р дэвтэрийг толилуулж байна.


88+82.3(1)

С-339

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-23147-23149

**Сэтгэл зүйн проектив судалгааны аргууд** / Эмхт. О.Оюунбилэг, Ч.Нармөнх; Хян. Д.Цогзолмаа.- УБ., 2020.- 122х.- ISBN: 978-9919-23-041-8.



Тус бүтээлийг цагдаагийн байгууллагын мөрдөгч ажилтнууд, сэтгэл зүйчид гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тандан судлах гэрч, хохирогчид сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг бие даан хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд туслах зорилгоор боловсруулсан болно. Энэхүү номыг мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэл засалчид, болон нийгмийн ажилтнууд, сурган хүмүүжүүлэгчид, хүүхдийн эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй мөрдөгч нарт зориулав.

88.8

С 974

/ХЗС-2/

ЭШФ Б-29635-29637

**Урлагт суурилсан нийгэм, сэтгэлзүйн дэмжлэгийг хэрхэн үзүүлэх вэ?:** Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага / Боловс. Хэйли Толл; Орч. Ж.Лхагвадулам; Хян. С.Тунгалагтамир, Н.Баярмаа, Эрдэнэчимэг.- УБ.: Адмон принт, 2017.- 84х.



Тус бүтээлд эмнэлзүйн сэтгэл засал, зөвлөгөө өгөх ур чадвар бүхий мэргэжилтнүүд, тухайлбал нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, аргазүйч, эмч, эмнэлгийн ажилтнууд өөрсдийн ажилдаа урлагийн сэтгэл засал эмчилгээг хэрэглэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дүрслэх урлагийг хэрхэн сэтгэл заслын эмчилгээнд хэрэглэж болох талаар мэдлэг чадвар олгох арга зүйн зөвлөмж болон эмчилгээнд хэрэглэх урлагт суурилсан дасгал ажлуудыг оруулсан болно.

88.6


У 491

ЭШФ Т-23243



## НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА

**Пунцагийн Бадарч:** Ардын уран зохиолч, Төрийн шагналт П.Бадарчийн мэндэлсний 80 жилийн ойд зорижлав: Санамж өгөх номзүй: (1960-2019) / Эмхт. Х.Ундрах; Хян. Д.Энхтунгалаг; Эх бэлт. Ч.Амарзаяа; Хавтасны дизайнер А.Нямлхагва.- УБ.: Соёмбо Принтинг, 2019.- 44х.



Уг номзүйн бүртгэлд Ардын уран зохиолч, Төрийн шагналт Пунцагийн Бадарчийн 1960-2019 онд бичиж хэвлүүлсэн, бие даасан зохиол бүтээлүүдээс гадна Монголын уран зохиолын дээжис 108 боть, тогтмол хэвлэлд нийтлэгдсэн, гадаад хэл дээр хэвлэгдсэн болон түүний хамтран оролцсон ба хянан засварласан зохиол бүтээлийг оруулан эмхэтгэсэн болно. Энэхүү ном зүйн бүртгэл нь уншигч, судлаач, номын сан-мэдээллийн ажилтны цаг завьг хэмнэх мэдээллийн гарын авлага болж, монголын утга зохиол судлалын эрдэм шинжилгээний судалгааг өргөжүүлэн тэлэхэд зохих хувь нэмэр оруулах нь дамжиггүй.

91.9:83

П 886

/ЛавФ 839/

ЭШФ Б-29606-29607

**Монгол бүжиг судлалын ном зүйн бүртгэл /** Эмхт. Х.Саранчимэг; Хян. Ж.Эрдэнэхорлоо.- УБ.: Удам соёл, 2019.- 71х.- ISBN: 978-9919-22-032-7.



Монгол улсын хэмжээнд хэвлэгдсэн монгол бүжгийн тухай дагнан бичсэн анхны өгүүллээс эхлэн 2019 оны эхний хагас жил хүртэлх хугацааг хамруулан дотор нь арав арван жилээр тоймлон ном, сурах бичиг, гарын авлага, өгүүлэл, нийтлэлээс гадна МУИС, СУИС-д хамгаалагдсан докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлүүд, мөн БНХАУ, ОХУ-д хэвлэгдсэн монгол бүжиг судлалын эрдэм шинжилгээний ажлын ном зүйн мэдээллийг бүртгэн тус номонд эмхэтгэжээ.

91.9:85

М 692


/ЛавФ- 838, НХУУТ-4/

ЭШФ-Т-23094-23095

ГАДААД ХЭЛ ДЭЭРХИ НОМУУД:

CHEMICAL SCIENCE

McMurry, John. **Organic chemistry**.- 7th ed.- Belmont: Thomson-Brooks, 2008.- 1224p.- 26cm.- ISBN: 978- 0-495-11628-8.




John McMurry's ORGANIC CHEMISTRY is consistently praised as the most clearly written book available for the course. In John McMurry's words: "I wrote this book because I love writing. I get great pleasure and satisfaction from taking a complicated subject, turning it around until I see it clearly from a new angle, and then explaining it in simple words." Through his lucid writing and ability to show the beauty and logic of organic chemistry, McMurry makes learning enjoyable. The highest compliment that can be given to a chemistry book applies to McMurry.

24.2

M 36

ГФ- 60 20090

Atkins, Peter., Friedman, Ronald W. **Molecular quantum mechanics**.- 4th ed.- NY.: Oxford University Press, 2005.- 573p.-25cm.- ISBN: 978-0-19-927498-7.



With the clarity of exposition and extensive learning features that have established the book as a leading text in the field, Molecular Quantum Mechanics takes us from the foundations of quantum mechanics, through quantum models of atomic, molecular, and electronic structure, and on to discussions of spectroscopy, and the electronic and magnetic properties of molecules. Lucid explanations and illuminating artworks help to visualise the many abstract concepts upon which the subject is built.


24.5

A 90

ГФ- 60 20113

WORLD STUDIES

Williamson, Alexander. **Journeys in North China, Manchuria, and Eastern Mongolia**: With Some Account of Corea: With illustrations and two maps.- London Smith, Elder, 1870.- 442p.- (V. 2).- ISBN: 9781357074562.



This work was reproduced from the original artifact, and remains as true to the original work as possible. Therefore, you will see the original copyright references, library stamps (as most of these works have been housed in our most important libraries around the world), and other notations in the work.

26.89(5Chi)

W 69

ГФ-60 20091

## BIOLOGICAL SCIENCE

White Tim D., Folkens Pieter A. **The human bone manual.**- Boston: Elsevier academic press, 2005.- 464p.- ISBN: 978-0-12-088467-4.



The Human Bone Manual is intended for use outside the laboratory and classroom, by professional forensic scientists, anthropologists and researchers. The compact volume includes all the key information needed for identification purposes, including hundreds of photographs designed to show a maximum amount of anatomical information. Provides multiple views of every bone in the human body Includes tips on identifying any human bone or tooth Incorporates up-to-date references for further study

28.70

W 63

ГФ 60 20071

Pelto Pertti J., Pelto Gretel H. **Anthropological research: The structure of inquiry.**- 2nd ed.- London: Cambridge University Press, 1978.- 333p.- ISBN: 978-0521292283.



